БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2021/01/СТА-ТЕЗ

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор хот.
2021.04.22

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
Аудитор: Н.Бүнчинсүрэн
Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: audit.mn

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат

Аудитын менежер
А.Цэзням

Тайланг бэлтгэсэн

Ахлах аудитор
Б.Должмаа
Аудитор
Н.Бүнчинсүрэн

2021 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр

Уг тайланг ҮАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:
*Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс*

## АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.. ........3
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ ........ 3
АУДИТЫН ЗОРИЛТ........ 3
АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ........ 3
АУДИТЫН АРГА ЗҮЙ ........ 3
АУДИТАД АШИГАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ........ 3
АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА, АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН... 4
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ, ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ЖУРАМ........ 4
ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ........ 4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР ........ 4
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ........ 5
БҮЛЭГ 1. ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАН ТӨЛӨВЛӨЖ, ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 112.7% БУЮУ 1680.3 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА........ 6
1.1. СУМДЫН ИТХ ТӨСӨВ БАТАЛСАН ТОГТООЛЫГ ГАРГАХДАА УРЬД ОНЫ ҮЛДЭГДЛИЙГ ХЯНААГҮЙГЭЭС 3 СУМ УРЬД ОНЫ ҮЛДЭГДЛЭЭС САНХҮҮЖИХ ЭХ ҮҮСВЭРИЙГ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЛЭЭС 10.8 САЯ ТӨГРӨГИЙГ ИЛҮҮ БАТАЛСАН БАЙНА. ........ 6
1.2. ХАНДИВ ТУСЛАМЖААР УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖЭЭС ОРОХ ОРЛОГО, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ОРЛОГО ТАСАРСНААС 2020 ОНД ТӨЛӨВЛӨСӨН ОРОН НУТГИЙН ОРЛОГЫГ БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА........ 13
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ТӨРИЙН САНГИЙН ДОТООД ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛДАГ ЗӨРЧИЛ БҮРЭН АРИЛАХГҮЙ БАЙНА........ 17
2.1. САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН PISCAL ПРОГРАММД ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАХ ЭРХИЙГ ЗӨРҮҮТЭЙ ТАТАЖ, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ГАРСАН ЗАРДЛААР ТАЙЛАГНАСНААС ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДЭСЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ БОЛОМЖГҮЙ БАЙНА. ........ 17
2.2. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ СУЛААС АУДИТААР ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР НИЙТ 4638.5 САЯ ТӨГРӨГИЙН АЛДАА ЗӨРЧИЛ ИЛЭРСЭН БАЙНА........ 20
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ........ 38
АУДИТЫН ДҮГНЭЛТ........ 39
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ........ 40

## АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/164 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт**

Монгол улсын төсвийн тухай хууль, Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх.
2. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх.
3. Өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлж ажилласан эсэх.

**Аудитын хамарсан хүрээ**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2020 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

**Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Шилэн дансны тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

| | |
|---|---|
| **Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн** | Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Н.Бүнчинсүрэн нар 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв. |
| **Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам** | Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв. |
| **Хүндрэл бэрхшээл** | Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн ахлах мэргэжилтэн төсөвт байгууллага, сангийн батлагдсан анхны болон тодотгосон төсвийн хуваарийг эх үүсвэр, зардлын ангиллаар гаргаж, нэгтгэж ирүүлдэггүй, аудитаас шаардсан мэдээ, судалгааг удаа дараа шаардуулж ирүүлдэг, бүрэн гаргаагүй зэрэг нь аудит хийхэд хүндрэл учруулсан болно. |

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт |
| АТӨЯХАТ | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| БСШУС | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэрлэл |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНӨ | Орон нутгийн өмч |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ТБОНӨХ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө |
| ТБОНӨХБАУХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЗШ | Тусгай зориулалтын шилжүүлэг |
| УТХ | Улсын тэмдэгтийн хураамж |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ЦХТАО | Цалин хөлс түүнтэй адилтгах орлого |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэг 19581.0 сая, тусгай зориулалтын шилжүүлэг 50938.5 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэг 7480.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг 486.4 сая, нийт 78485.9 сая төгрөгийн тусламжийн орлого, 10374.0 сая төгрөгийн татварын, 8013.1 сая төгрөгийн татварын бус орлогыг оруулж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсвийн зарлагыг нийт 96873.1 сая төгрөгийн төсөв баталснаас урсгал зардалд 86803.2 сая, хөрөнгийн зардалд 10069.9 сая төгрөгийг хуваарилсан байна.

Тайлант онд аймгийн Засаг даргын захирамжаар 3 удаа төсөвт зохицуулалт хийж, аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн 21/03 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, анхны батлагдсан төсвийг 2634.9 сая төгрөгөөр төсвийг бууруулан нийт 94238.1 сая төгрөгөөр төсвийг баталж, батлагдсан төсөвт аймгийн Засаг дарга төсөвт зохицуулалт хийх захирамжийг 3 удаа гаргасан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2020 оны орлогыг 7709.9 сая төгрөгөөр баталснаас татварын орлогыг 2967.1 сая, бусад орлогыг 540.6 сая, орон нутгийн байгууллагууд өөрийн орлогоор 34.1 сая, Соёлын төвүүд өөрийн орлогоор 9.3 сая, ерөнхий боловсролын сургуулиуд 25.5 сая, өөрийн ОНХС-ийн орлогоор 540.6 сая, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 1499.0 сая төгрөг оруулж, урьд оны үлдэгдлээс 2634.2 сая төгрөгөөр санхүүжихээр баталжээ.

Сангийн яамны 2020.04.30-ний өдрийн 12-1/2915, БШУС-ын 2020.11.17-ний өдрийн 1а/2815 дугаар албан бичгээр улсын төвөөс батлагдаж олгосон СӨБ-ийн тусгай зориулалтын шилжүүлгээс 2020 онд 1404.3 сая, ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлгээс 1216.5 сая, нийт 2620.8 сая төгрөгийг БШУЯ-нд төвлөрүүлж, Сангийн яамнаас 2021.03.30-ны өдөр ҮАГ-т хүргүүлсэн 12-1/1473 дугаар албан бичгийн дагуу СӨБ-ийн хэмнэлтээс 448.3 сая, ЕБС-ийн 388.3 сая, нийт 836.6 сая төгрөгийг улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээс хасаж, дотуур байрын болон цэцэрлэгийн хоолны зардлыг бууруулж залруулгыг 2021.04.17-ний өдөр хийсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн дүнгээр дээрх 836.6 сая төгрөгийг хасаж 2020 онд 87309.5 сая төгрөгийг зарцуулснаас урсгал зардалд 80417.8 сая, хөрөнгийн зардалд 6891.7 сая төгрөг зарцуулсан байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын СТСХ гаргаж ажилласан хэдий ч зөрчил бүрэн арилаагүй байна.

# АУДИТЫН ДҮН

## БҮЛЭГ 1. ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАН ТӨЛӨВЛӨЖ, ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 112.7% БУЮУ 1680.3 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

### 1.1. Сумдын ИТХ төсөв баталсан тогтоолыг гаргахдаа урьд оны үлдэгдлийг хянаагүйгээс 3 сум урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 10.8 сая төгрөгийг илүү баталсан байна.

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 19581.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 50938.5 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 7480.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлгийг 486.4 сая, татварын орлогыг 8591.0 сая, татварын бус орлогыг 1.0 сая, нийт 88076.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

2. Аймгийн СТСХ-ээс Сангийн яаманд татварын орлогыг 7885.0 сая, хүү, торгуулийн орлогыг 50.0 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 50.0 сая, нийт 8855.0 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яам татварын орлогыг 706.0 сая, хүү торгуулийн орлогыг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бусад орлогыг 50.0 сая төгрөгөөр хэвээр баталж, 2020 онд орон нутгийн урсгал орлогоор нийт 9591.0 сая төгрөгийг оруулахаар хянасан байна.

3. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн татварын орлогыг 10374.0 сая, хүү торгуулийн орлогыг 972.5 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 51.0 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 239.2 сая хандивын орлогоор 1200.0 сая, бусад орлогыг 3686.0 сая төгрөгөөр баталж, урьд оны үлдэгдлээс 1755.3 сая төгрөгийг санхүүжүүлж, Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулиар баталсан улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийг оролцуулан 2020 оны аймгийн төсвийг 96763.9 сая төгрөгөөр баталжээ.

4. Аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн хуралдааны 21/03 дугаар "Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор аймгийн төсвийг 2635.0 сая төгрөгөөр хасаж тодотгон, 94238.1 сая төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 1. Аймгийн 2020 оны төсвийн суурь зарлагын эх үүсвэр /сая төгрөг/*

| № | Үзүүлэлт | Сангийн яамны хянасан дүн | Анх батлагдсан төсөв | Тодотголоор оруулсан өөрчлөлт | Нийт батлагдсан төсөв |
|---|---|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 | 3 | 4 |
| | **ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар** | Монгол Улсын Сангийн сайдын 2019.11.25-ний өдрийн 4-1/7847 албан бичиг | АИТХ-ын 2018.11.29-ны өдрийн 18/16, сумдын ИТХ-ын тогтоолууд | АИТХ-ын 2020.09.18-ны өдрийн 21/03 тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолууд | |
| **А** | **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **88,076.9** | **96,873.1** | **(2,635.0)** | **94,238.1** |
| **1** | **УРСГАЛ ОРЛОГО** | **9,591.0** | **11,397.5** | **524.2** | **11,921.7** |
| **1.1** | Татварын орлого | 8,591.0 | 10,374.0 | 479.6 | **10,853.6** |
| **1.2** | Татварын бус орлого | 1,000.0 | 1,023.5 | 44.6 | **1,068.1** |
| **2** | **ХӨРӨНГИЙН ОРЛОГО** | | | | **-** |
| **3** | **ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГО** | **-** | **1,200.0** | **-** | **1,200.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4** | **ТУСЛАМЖИЙН ОРЛОГО** | **78,485.9** | **78,485.9** | **(3,747.7)** | **74,738.2** |
| **4.1** | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 19,581.0 | 19,581.0 | (816.8) | 18,764.2 |
| **4.2** | Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг | 7,480.0 | 7,480.0 | (1,054.2) | 6,425.8 |
| **4.3** | Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг | 50,938.5 | 50,938.5 | (1,876.7) | 49,061.8 |
| **4.4** | Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг | 486.4 | 486.4 | - | 486.4 |
| **5** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | - | **5,789.6** | **588.5** | **6,378.1** |
| **5.1** | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | **239.2** | **-53.2** | **185.9** |
| **5.2** | Бусад орлого | - | **3,795.2** | **109.7** | **3,904.8** |
| **5.3** | Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих | - | **1,755.3** | **532.0** | **2,287.3** |

*Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд*

5. Аймгийн Засаг дарга 2020 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан аймгийн төсөвт нийт 6 удаагийн захирамжаар төсөвт зохицуулалт хийжээ. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1[1], 42.2.2[2] дахь заалт, Улсын онцгой комиссын 2020.02.10-ний өдрийн 04 тоот хурлын тэмдэглэл, БСШУСС-ын 2020.02.13-ний өдрийн 1а/864 дүгээр тушаал, аймгийн ИТХ-ын 2019.11.29-ний өдрийн “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 18/16 дугаар тогтоол зэргийг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2020.03.11-ний өдрийн А/146 дугаар захирамжаар орон нутгийн 3 байгууллагын төсөв хооронд 12.8 сая төгрөгийн зохицуулалт хийсэн;
- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2019.11.29-ний өдрийн “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 18/16 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2020.05.29-ний өдрийн А/347 дугаар захирамжаар ангилагдаагүй зардлаас санхүүжих 2 арга хэмжээний зардалд батлагдсан 95.0 сая төгрөгийг хасаж, аймгийн ЗДТГ-ын Засаг даргын нөөц хөрөнгөд нэмж баталсан;
- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2019.11.29-ний өдрийн “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 18/16 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2020.07.09-ний өдрийн А/446 дугаар захирамжаар ангилагдаагүй зардлаас санхүүжих 2 арга хэмжээний зардалд батлагдсан 124.0 сая төгрөгийг хасаж, аймгийн ЗДТГ-ын Засаг даргын нөөц хөрөнгөд нэмж баталж, Халамжийн санд 28.6 сая, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсөвт 10.0 сая төгрөгийн зохицуулалтыг тус тус хийсэн;
- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн “Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 21/03 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2020.10.27-ний өдрийн А/701 дүгээр захирамжаар ангилагдаагүй зардалд батлагдсан парк орчмын бүтээн байгуулалтын ажлын 347.6 сая төгрөгийг хасаж, Засаг даргын нөөц хөрөнгөд нэмж зохицуулалт хийсэн;
- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1[3], 42.2.2[4] дахь заалт, аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн “Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт

---

*[1] “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно” 42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:*

*[2] “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд”*

*[3] “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно” 42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:*

*[4] “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд”*

оруулах тухай" 21/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020.11.12-ний өдрийн "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" А/751 дугаар захирамжийг үндэслэн 2020.11.27-ний өдөр А/770 дугаар захирамж гарган, орон нутгийн 60 байгууллага, 29 сургууль, 37 цэцэрлэг, тусгай сургууль болон сумын 17 эрүүл мэндийн төвийн төсөвт зохицуулалт хийсэн;

- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1[5], 42.2.2[6] дахь заалт, аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн "Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 21/03 дугаар тогтоол, БСШУСС-ын 2020.11.13-ний өдрийн 1а/2788 дугаар "Төсөвт зохицуулалт хийх тухай" албан бичгийг үндэслэн аймгийн Засаг даргын 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар орон нутгийн төсөвт 5 байгууллага, ангилагдаагүй зардлын, хоёрдугаар хавсралтаар тусгай зориулалтын шилжүүлгийн 69 байгууллагын, гуравдугаар хавсралтаар эрүүл мэндийн салбарын 3 байгууллагын төсөвт зохицуулалт тус тус хийсэн байна.

6. Сангийн яамны 2020.04.30-ний өдрийн 12-1/2915, БШУС-ын 2020.11.17-ний өдрийн 1а/2815 дугаар албан бичгээр улсын төвөөс батлагдаж олгосон СӨБ-ийн тусгай зориулалтын шилжүүлгээс 2020 онд 1404.3 сая, ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлгээс 1216.5 сая, нийт 2620.8 сая төгрөгийг БШУЯ-нд төвлөрүүлж, СӨБ-ийн хэмнэлт, ЕБС-ийн хэмнэлт дансанд бүртгэсэн байна. Төвлөрүүлэлтийг БСШУСЯ-ны ТЗШ байгууллагын хэмнэлтийн 100900015902 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

| Огноо | Мөнгөн дүн | |
|---|---|---|
| | СӨБ | ЕБС |
| 2020.04.24 | 800.0 | 893.4 |
| 2020.06.23 | 523.4 | - |
| 2020.12.24 | 21.7 | 117.0 |
| 2020.12.30 | 59.2 | 206.1 |
| **Дүн** | 1,404.3 | 1,216.5 |

7. Сангийн яамнаас 2021.03.30-ны өдөр ҮАГ-т ирүүлсэн 12-1/1473 дугаар албан бичгийн дагуу СӨБ-ийн хэмнэлтээс 448.3 сая, ЕБС-ийн 388.3 сая, нийт 836.6 сая төгрөгийг улсаас авах тусгай зориулалтын шилжүүлгээс хасаж, хоолны зардлыг бууруулах залруулгыг 2021.04.17-ний өдөр хийсэн ба тус албан бичигт БСШУЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын даргын 2020.01.29-ний өдрийн 13/376 дугаар албан бичгийн хавсралтыг аймаг бүрээр гаргаж ирүүлжээ. Дээд шатны байгууллагаас улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийг хассан байхад зардлыг хасаж тодотгоогүй байгаа ба шалтгааныг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн мэргэжилтнээс тодруулахад Сангийн яамнаас зардлын дүнг бууруулахгүй гэсэн чиглэл өгсөн байна.

8. Өмнөх оны аудитаар "Төсөвт байгууллагуудын төсвийн төсөлд тавих хяналтыг сайжруулж, төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийдэг, зохицуулалт хийсэн шийдвэрийг гүйлгээ гарсны дараа гаргадаг байдлыг таслан зогсоох" зөвлөмжийг аймгийн Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт хүргүүлсэн байхад уг зөрчлийг 2020 онд давтан гаргасан байна.

[5] *"Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно" 42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:*

[6] *"Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд"*

***Аудитын илрүүлэлт:***

- *Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт"-ийг нэгдүгээр хавсралтаар баталсан гэсэн болович аудитад тус хавсралтыг ирүүлээгүй;*
- *Аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2020.03.11-ний өдрийн А/146 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зохицуулалтыг баталсан гэсэн болович хоёрдугаар хавсралт байхгүй, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад зохицуулалт хийгээгүй;*
- *Сангийн яамны 2020.12.16-ний өдрийн 12-2/7742 дугаар албан бичгээр төрийн сангийн гүйлгээг 2020.12.25-ний өдөр хаахаар заасан байхад төсөвт зохицуулалт хийсэн захирамжийг аймгийн Засаг дарга 2020.12.31-ний өдөр гаргасан байна.*

Оны эцэст төсөвт зохицуулалт хийсэн аймгийн Засаг даргын 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжийн талаар аймгийн СТСХ-ийн төсвийн 2 мэргэжилтнээс тодруулахад "Төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, тэвчиж болох зардлуудын хуваарийг хойшлуулахдаа төсвийн үлдэгдэл, зарцуулах эрхийг зөрүүлж татсан, хойшлуулсан зардлын эрхийг нээхдээ зарцуулах эрхийг давхардуулан татсантай холбоотой 2020 оны батлагдсан төсвөөс илүү зарцуулалт гаргасныг 2021.01.12, 2021.01.28-ний өдрүүдэд залруулга хийх файл ирсний дагуу 2 удаагийн залруулга хийсэн, Сангийн яам нь аймгийн ТЕЗ-ийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж хууль зөрчдөг, орон нутгаас санал авахгүйгээр шийдвэрлэдэг" гэсэн тайлбар бичгийг ирүүлсэн байна. Энэ байдал нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16[7], 41 дүгээр зүйлийн 41.1[8], 41.2.2[9] заалтуудыг зөрчиж байгаа тул "Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан төсвийг хянаж хүлээн авч, төсвийн төлөвлөлтийг үнэн зөв оруулж, төсвийн орлого, зардлыг үнэн зөв тайлагнаж байгаад тавих хяналтыг сайжруулж, программын хөгжүүлэлтийн нэн даруй хийх" саналыг ҮАГ-аар дамжуулан Сангийн яаманд уламжлахаар тайланд тусгав.

9. Өмнөх жилүүдийн аудитаар аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталсан, Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд батлагдсан төсвийг зөрүүтэй оруулсан өмнөх оны зөрчил арилаагүй байна.

***Аудитын илрүүлэлт:***

- *Сумдын төсөв баталсан тогтоолоор баталсан урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган шалгахад Галуут сум орон нутгийн ерөнхий орлогын харилцах дансны эхний үлдэгдлээс 1.9 сая, Баян-Овоо сум ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдлээс 4.9 сая, Бөмбөгөр сум ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдлээс 4.0 сая, нийт 10.8 сая төгрөгийг илүү баталсан;*
- *Эрдэнэцогт сумын ИТХ-н хуралдааны 2019.11.27-ний өдрийн 117 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 1.0 сая төгрөгөөр баталсныг 2020.09.25-ний өдрийн сумын төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 13/01 дүгээр тогтоолоор ЗДТГ-ын өөрийн орлогыг 2.0 сая*

---

[7] *Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох;*

[8] *Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ:*

[9] *Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;*

*төгрөгөөр тодотгон баталсан байхад Сангийн яамны Э-Тайланд өөрийн орлогын төлөвлөгөөг 1.0 сая төгрөгөөр оруулсан байна.*

10. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 2.1.10-т асруулагчдын тэтгэврийн 30 хувийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн төсөвт оруулахаар заасан байхад аймгийн Асрамжийн газрын төсвийн бүрэлдэхүүнд тус орлогыг оруулж баталдаггүй бөгөөд асруулагчийн тэтгэврийн орлогыг Асрамжийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулж байна. Иймд аймгийн Асрамжийн газрын 2022 оны төсөвт дээрх орлогыг хуулийн дагуу төлөвлөх зөвлөмжийг аймгийн СТСХ-т хүргүүлэв.

11. Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны орлогыг аймгийн ИТХ-аар 86419.0 сая, сумын ИТХ-аар 7819.0 сая, нийт 94238.1 сая төгрөгөөр төлөвлөсөн нь байна.

*Хүснэгт 2 .Төсвийн эх үүсвэр /аймаг, сумаар, сая төгрөгөөр/*

| НИЙТ ОРЛОГО | АЙМАГ | СУМ | ДҮН |
|---|---|---|---|
| Татварын орлого | 8,074.6 | 2,779.0 | 10,853.6 |
| Хүү, торгуулийн орлого | 780.0 | 188.1 | 968.1 |
| Хандив тусламжийн орлого | 1,200.0 | 43.4 | 1,243.4 |
| Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 100.0 | | 100.0 |
| Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 18,764.2 | | 18,764.2 |
| Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг | 6,425.8 | | 6,425.8 |
| Аймгийн төсөвт Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг | 49,061.8 | | 49,061.8 |
| Аймгийн төсөвт Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг | 486.4 | | 486.4 |
| Аймгийн орон нутгийн байгууллагын өөрийн орлого | 117.0 | 3,930.3 | 4,047.3 |
| Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл | 1,409.2 | 878.2 | 2,287.3 |
| **ДҮН** | 86,419.0 | 7,819.0 | 94,238.1 |

*Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд*

12. Татварын орлогыг өмнөх онд 8870.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 12059.9 (136.0%) сая төгрөг орсон бөгөөд 2020 онд татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 1260.8 сая, өмнөх оноос 914.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 10853.6 сая төгрөгөөр төлөвлөж, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод Сангийн яамны баталсан дүнгээс 240.0 сая төгрөгөөр бууруулж, төрийн аудитын байгууллагын зөвлөмжийн дагуу өмнөх онуудын бодит гүйцэтгэлд тулгуурлан олгохоор 452.4 сая төгрөгийг олгохоор баталжээ.

*Хүснэгт 3. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/*

| Орлогын төрөл | 2018 оны гүйцэтгэл | 2019 онд Сангийн яамны хянасан | 2019 оны төлөвлөгөө | 2019 оны гүйцэтгэл | 2020 онд Сангийн яамны хянасан | 2020 оны анх баталсан төлөвлөгөө | 2020 оны тодотгосон төлөвлөгөө | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Өмнөх оны төлөвлөгөөнөөс | Сангийн яамны хянаснаас |
| **Татварын орлогын дүн** | 8,543.8 | 7,610.0 | 8,870.8 | 12,059.9 | 8,480.0 | 10,371.0 | 10,853.6 | 914.7 | 1,260.8 |
| **1.Аймгийн нэгдсэн төсөв төсөв** | 5,288.8 | 5,281.9 | 5,639.0 | 6,840.5 | 5,550.0 | 5,855.0 | 6,604.1 | 631.6 | 357.1 |
| а. ЦХТАО /суутган-1/ | 5,101.7 | 5,252.8 | 5,253.0 | 5,467.2 | 5,400.0 | 5,600.0 | 6,000.0 | 203.0 | 0.2 |
| б. Хувь хүний орлогын татварын буцаан олголт | (656.6) | (800.0) | (560.0) | (548.0) | (800.0) | (800.0) | (452.38) | 240.0 | 240.0 |
| в. АТӨЯХАТ | 441.4 | 420.0 | 426.0 | 507.6 | 430.0 | 500.0 | 500.0 | (7.0) | 6.0 |
| г.Газрын төлбөр | 118.6 | 160.0 | 270.0 | 1,130.9 | 250.0 | 270.0 | 271.5 | 146.0 | 110.0 |
| д. Үл хөдлөх хөрөнгийн татвар | 283.7 | 249.1 | 250.0 | 282.8 | 270.0 | 285.0 | 285.0 | 49.6 | 0.9 |

| Орлогын төрөл | 2018 оны гүйцэтгэл | 2019 онд Сангийн яамны хянасан | 2019 оны төлөвлөгөө | 2019 оны гүйцэтгэл | 2020 онд Сангийн яамны хянасан | 2020 оны анх баталсан төлөвлөгөө | 2020 оны тодотгосон төлөвлөгөө | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Өмнөх оны төлөвлөгөөнөөс | Сангийн яамны хянаснаас |
| **2. Орон нутгийн төсөв** | 3,255.0 | 2,328.1 | 3,231.8 | 5,219.4 | 2,930.0 | 4,516.0 | 4,249.5 | 283.1 | 903.7 |
| **Хүн амын орлого** | 1,601.0 | 1,306.5 | 1,481.0 | 1,924.0 | 1,625.0 | 1,781.0 | 1,813.9 | 254.0 | 174.5 |
| 1. Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/ | 482.1 | 308.0 | 381.0 | 779.5 | 430.0 | 467.0 | 462.6 | (70.5) | 73.0 |
| 2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар | **0.7** | **96.1** | **100.0** | **220.4** | **50.0** | **50.0** | **52.4** | 20.0 | **3.9** |
| 3. Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүү/ | **1,063.0** | **855.9** | **950.5** | **1,144.5** | **1,100.0** | **1,210.0** | **1,244.9** | 300.5 | **94.6** |
| 4. Бууны татвар | **55.2** | **46.5** | **49.5** | **50.4** | **45.0** | **54.0** | **54.0** | 4.0 | **3.0** |
| **5. Бусад төлбөр хураамж** | **1,654.0** | **1,021.6** | **1,750.8** | **1,869.4** | **1,305.0** | **2,735.0** | **2,435.6** | **29.1** | **729.2** |
| а.Улсын тэмдэгтийн хураамж | 247.9 | 270.0 | 273.2 | 305.1 | 285.0 | 300.0 | 298.1 | 36.2 | 3.2 |
| б. Газрын дуудлага худалдааны орлого | 321.6 | - | 150.0 | 54.1 | 10.0 | 710.0 | 712.0 | (50.0) | 150.0 |
| в. Орон нутгийн зам ашигласны төлбөр | - | - | 194.6 | 16.3 | - | 220.0 | 220.0 | 46.8 | 194.6 |
| г. Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 314.8 | 300.0 | 506.3 | 481.8 | 400.0 | 658.3 | 656.3 | 197.8 | 206.3 |
| д.ус рашаан ашигласны төлбөр | 264.6 | 200.0 | 253.3 | 334.1 | 265.0 | 350.9 | 450.9 | (146.7) | 53.3 |
| е..Түгээмал тархацтай АМАТөлбөр | 12.0 | 12.0 | 25.7 | 25.4 | 10.0 | 33.0 | 37.7 | 13.7 | 13.7 |
| ё.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны | 468.5 | 239.6 | 339.5 | 515.6 | 335.0 | 458.0 | 55.6 | (68.4) | 99.9 |
| ж.Нохойны татвар | 8.9 | - | 8.2 | 8.8 | - | 4.8 | 5.0 | (0.3) | 8.2 |
| з.Бусад татвар | 15.7 | - | - | 128.2 | - | | - | - | - |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019, 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

13. Татварын орлогыг өмнөх оны гүйцэтгэл, Сангийн яамнаас хянасан дүн, мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаанд үндэслэн төлөвлөсөн бөгөөд төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн 8 хувиар нэмэх тогтоолыг Засгийн газар гаргасан, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн, хадгаламж эзэмшигчдийн тоо сүүлийн жилд нэмэгдсэн, үндэсний үйлдвэрт малын түүхий эд тушаасан малчин иргэдэд олгох мөнгөн урамшууллыг Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор 50% нэмэгдүүлж өгсөн зэрэгтэй холбоотой зарим татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдүүлэн баталсан байна.

14. Орлогын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад хүү торгуулийн орлогыг 5.4 сая төгрөгөөр бууруулж, бусад татварыг орлогын нэр төрөл тус бүрээр өмнөх оноос нэмэгдүүлснээс татварын орлогыг 1982.8 сая, төсөвт байгууллага, сангийн өөрийн орлогыг 1774.5 сая, хандив, тусламжийн орлогыг 658.4 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 24.0 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.




Хандив тусламжийн орлогыг өмнөх онд 585.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 аж ахуйн нэгжээс 135.0 сая төгрөгөөр оруулсан бол аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.11.27-ний өдрийн 117 дугаар тогтоолоор уул уурхайн ашиглалтын чиглэлээр 2020 онд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдээс орон нутагт үзүүлэх хандив дэмжлэгийн доод хэмжээг тогтоож, хандивын 70 хувь буюу

1200.5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 30 хувь буюу 514.5 сая төгрөгийг үйл ажиллагаа явуулж байгаа сумын ОНХС-д оруулж, нийт 1715.0 сая төгрөгийг оруулахаар баталсны дагуу аймгийн ОНХС хандив тусламжийн орлогыг 1200.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

15. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг Сангийн яамнаас 50.0 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолоор 51.0 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн 21/03 дугаар тогтоолоор 49.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 100.0 сая төгрөгөөр баталжээ.

16. Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 15353.9 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2573.7 сая, Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийг 46216.6 сая, ЭМДС-аас олгох санхүүжилтийг 486.4 сая, нийт 63025.1 сая төгрөгөөр баталж, урьд оны үлдэгдлээс 3462.5 сая, аймгийн төсөвт байгууллагуудад нийт 16814.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

*Хүснэгт 4 .Сумдын төсвийн эх үүсвэрийн судалгаа /сая төгрөгөөр/*

| Санхүүжилтийн эх үүсвэр | Мөнгөн дүн | Хувь |
|---|---|---|
| Төсөвт байгууллагуудын өөрийн орлого | 68.9 | 0.1 |
| Хүү торгуулийн орлого | 242.5 | 0.3 |
| Хандив тусламжийн орлого | 298.1 | 0.4 |
| ЭМДС-ийн санхүүжилт | 486.4 | 0.7 |
| СХС-ийн орлого | 1,499.0 | 2.1 |
| ОНХС-ийн сангаас санхүүжих | 2,573.7 | 3.6 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 2,634.2 | 3.6 |
| Татварын орлого | 2,958.2 | 4.1 |
| Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг | 15,353.9 | 21.2 |
| Тусгай зориулалтын шилжүүлэг | 46,216.6 | 63.9 |
| **ДҮН** | 72331.5 | 100 |

*Эх сурвалж: Сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд*

17. Сумдын дүнгээр нийт 72331.5 сая төгрөг баталснаас төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 30.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 68.9 сая төгрөгөөр баталснаас 34.1 сая төгрөгийг сумын ЗДТГ-ууд 25.5 сая төгрөгийг ерөнхий боловсролын сургуулиуд, 9.3 сая төгрөгийг сумдын соёлын төвүүд өөрийн орлогоор оруулахаар төлөвлөжээ.

18. Сумын Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн орлогын эргэн төлөлтөөр 2020 онд 20 сум 1499.0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж, 4 сум үндсэн үйл ажиллагааны орлогоор 64.0 сая, 7 сум туслах үйл ажиллагааны орлогоор 476.6 сая, нийт 540.6 сая төгрөгийг ОНХС-д оруулахаар төлөвлөжээ.

*Хүснэгт 5 .Сумын СХС, ОНХС-ийн орлогын төлөвлөгөө /сая төгрөгөөр/*

| № | Сумын нэр | СХС | ОНХС |
|---|---|---|---|
| 1 | Галуут | 97.6 | 140.00 |
| 2 | Баян-Овоо | 60.0 | 196.53 |
| 3 | Эрдэнэцогт | 63.3 | - |
| 4 | Бууцагаан | 100.0 | 9.90 |
| 5 | Жинст | 95.5 | |
| 6 | Богд | 81.6 | |
| 7 | Баянлиг | 36.0 | 27.47 |
| 8 | Баянговь | 25.0 | 27.70 |
| 9 | Гурванбулаг | 95.4 | |
| 10 | Жаргалант | 124.1 | 5.35 |
| 11 | Заг | 21.0 | |
| 12 | Баацагаан | 123.5 | 3.51 |
| 13 | Бөмбөгөр | 53.0 | 55.00 |
| 14 | Өлзийт | 50.8 | 10.95 |
| 15 | Хүрээмарал | 65.3 | 34.21 |
| 16 | Баянбулаг | 70.0 | |
| 17 | Шинэжинст | 32.0 | |
| 18 | Баянцагаан | 55.0 | |
| 19 | Баян-Өндөр | 72.2 | 30.00 |
| 20 | Баянхонгор | 177.8 | |
| | ДҮН | 1499.0 | 540.6 |

*Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд*

## 1.2. Хандив тусламжаар уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжээс орох орлого, сум хөгжүүлэх сангийн орлого тасарснаас 2020 онд төлөвлөсөн орон нутгийн орлогыг биелүүлж ажиллаагүй байна.

19. Аймгийн дүнгээр 2020 онд орон нутгийн орлогоор 13272.8 сая төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 14953.1 (112.7%) сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 1680.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 6 . Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Нийт орлого ба тусламжийн дүн | 12,180.55 | 13,272.83 | 14,953.1 | 1,680.26 | 112.66 |
| Татварын орлого | 10,684.30 | 10,853.64 | 12,351.32 | 1,497.68 | 113.80 |
| Орлогын албан татвар | 6,755.90 | 7,307.52 | 8,454.61 | 1,147.09 | 115.70 |
| Хөрөнгийн албан татвар | 834.66 | 839.00 | 993.90 | 154.90 | 118.46 |
| Бусад татвар, төлбөр хураамж | 3,093.74 | 2,707.13 | 2,902.81 | 195.68 | 107.23 |
| Татварын бус орлого | 1,496.25 | 2,419.19 | 2,601.77 | 182.58 | 107.55 |
| Нийтлэг бус татварын орлого | 1,290.06 | 1,119.19 | 1,727.35 | 608.17 | 154.34 |
| Хөрөнгийн орлого | 71.19 | 100.00 | 269.05 | 169.05 | 269.05 |
| Тусламжийн орлого | 135.00 | 1,200.00 | 605.36 | (594.64) | 50.45 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019, 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

20. Тайлант онд төлөвлөсөн татварын орлогыг 10853.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12351.3 сая (113.8%) биелүүлсэн бөгөөд газрын төлбөр, бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын дуудлага худалдааны орлогоос бусад татварын орлогыг 102-266 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 7 .Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

| Д/Д | Татварын орлогын төрөл | Орон нутгийн жилийн эцсийн тайлангаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Зөрүү |
| 1 | **А.Орон нутгийн нийт орлого** | **13,272.8** | **14,953.1** | **112.7** | **1,680.3** |
| 2 | **Татварын дүн** | **10,853.6** | **12,351.3** | **113.8** | **1,497.7** |
| 3 | **1.Аймгийн төсөв** | **6,604.1** | **7,182.6** | **108.8** | **578.5** |
| | 1. ЦХТАО /суутган-1/ | 6,000.00 | 6,475.1 | 107.9 | 475.1 |
| | Буцаан олголт | (452.38) | (452.7) | 100.1 | -0.4 |
| | 2. АТӨЯХАТ | 500.00 | 587.5 | 117.5 | 87.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3. Үл хөдлөх хөрөнгийн татвар | 285.00 | 360.2 | 126.4 | 75.2 |
| | 4.Газрын төлбөр | 271.50 | 212.6 | 78.3 | -58.9 |
| 2 | **2. Орон нутгийн төсөв** | **4,249.520** | **5,168.7** | **121.6** | **919.2** |
| 1 | **Хүн амын орлого** | **462.6** | **1,009.1** | **218.1** | **546.5** |
| | 1..ИОТТХ | 462.58 | 1,009.1 | 218.1 | 546.5 |
| | **Хадгаламжийн хүүгийн орлого** | **1,244.91** | **1,283.6** | **103.1** | **38.7** |
| 2 | **2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны** | **52.40** | **139.6** | **266.4** | **87.2** |
| 3 | **3. Бууны татвар** | **54.00** | **46.2** | **85.6** | **-7.8** |
| 4 | **5. Бусад төлбөр хураамж** | **2,435.63** | **2,690.2** | **110.5** | **156.3** |
| | а.Улсын тэмдэгтийн хураамж | 298.13 | 282.5 | 94.7 | -15.7 |
| | в. Газрын дуудлага худалдаа | 712.00 | 678.6 | 95.3 | -33.4 |
| | д. Хог хаягдлын хураамж | 656.30 | 673.4 | 102.6 | 17.1 |
| | д.ус рашаан ашигласны төлбөр | 450.90 | 584.7 | 129.7 | 133.8 |
| | ё.Түгээмал тархацтай АМАТөлбөр | 37.70 | 40.3 | 106.8 | 2.6 |
| | з.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны | 55.60 | 176.5 | 317.5 | 120.9 |
| | й.Нохойны татвар | 5.00 | 1.2 | 23.7 | -3.8 |
| | е.Бусад татвар /орон нутгийн зам ашигласны хураамж/ | 220.00 | 253.1 | 115.0 | 33.1 |
| 6 | **Татварын бус орлого** | **968.0855** | **1,596.5** | **164.9** | **628.4** |
| | Хүү торгууль | 968.09 | 1,596.5 | 164.9 | 628.4 |
| 7 | **ТБӨО** | **151.10** | **130.9** | **86.6** | **-20.2** |
| 8 | **Хандив** | **1,200.00** | **605.4** | **50.4** | **-594.6** |
| 9 | **Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлого** | 100.00 | 269.1 | 269.1 | 169.1 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Орон нутгийн орлого давж биелэхэд дараах татварын орлого голлох нөлөөг үзүүлсэн байна.Үүнд:

- ✓ Засгийн газрын 201912.25-ний өдрийн 472 дугаар тогтоолоор цалинг 8% нэмсэн, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор 2020.01.01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 420.0 мянган төгрөгөөр тогтоосон, Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч “Наранмандал Энтерпрайзес” ХХК-ийн ажилчдыг Баянхонгор аймагт татвар төлөгчөөр бүртгэх бодлого баримталж ажилласан;
- ✓ “Эрдэнэс таван толгой ХК-ийн 2019 оны ногдол ашгийг 2020 оны 09 дүгээр сард иргэдийн дансанд шилжүүлж, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу 10 хувийн татварыг авсан ;
- ✓ Татварын шинэчлэлийн хүрээнд үл хөдлөх татварын хөрөнгө борлуулахад нэхэмжлэл нь иргэний нэр дээр үүсэж, төлсөн татвар нь тус иргэний харьяалал бүхий суманд төвлөрдөг механизм бий болсон;
- ✓ Аймгийн хэмжээнд 2020 онд 1500 гаруй тээврийн хэрэгсэл нэмэгдсэн, 2020 онд орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид өөрийн нэр дээр үүсгэсэн татварын өрийг төлсөн;

- ✓ Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанаас ногдуулалтыг бүрэн төвлөрүүлэх, урьд оны ус, рашаан ашигласны төлбөрийг барагдуулах арга хэмжээг удаа дараа авсан байна.

21. Тайлант онд төлөвлөсөн татварын орлогыг биелүүлж ажилласан ч зарим татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- ✓ Дэлхий нийтэд цар тахал гарсантай холбоотой татвар хураалт багассан, аялал жуулчлал, ан агнуур өмнөх жилээс эрс багассан;
- ✓ Татварын шинэчлэлийн хүрээнд газрын төлбөрийн ногдуулалтад нэхэмжлэлийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас бүрэн хийж дуусаагүй, газрын дуудлага худалдаа цахимаар явагдаж байгаагаас төлөвлөснөөс бага үнээр ялагч тодрох магадлал үүссэн;
- ✓ Сангийн яамнаас нохойны албан татварыг төлөвлөхгүй гэсэн чиглэл ирүүлсэн, Баацагаан, Галуут, Өлзийт, Баянцагаан сумд нохойны албан татвараар 5.0 сая төгрөг оруулахаар баталж 1.2 сая төгрөгийг оруулсан, бусад сумдад нохойны татварыг хураан авч нохой устгалд зарцуулах чиглэлийг өгсөн ба зарим сум нохойны албан татварыг сумын ЗДТГ-ын өөрийн орлогоор тайлагнажээ.

22. Хүү торгуулийн орлогыг 968.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс аймгийн Төрийн аудитын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газраас тогтоосон торгууль, төлбөрийн актын дүн өмнөх оноос нэмэгдсэнээс шалтгаалж, хүү торгуулийн орлогоор 1596.5 (164.9%) сая төгрөгийг оруулжээ.

23. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 1624.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоор 1909.5 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоор 1484.1 (91.4%) сая, туслах үйл ажиллагааны орлогоор 1113.4 (58.3%) сая төгрөг оруулж, өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

*Хүснэгт 8..Байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

| Байгууллага | Үндсэн үйл ажиллагаа | | | | Туслах үйл ажиллагаа | | | | Нийт орлого | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төл | Гүй | Зөрүү | Хувь | Төл | Гүй | Зөрүү | Хувь | Төл | Гүй | Зөрүү | Хувь |
| ЗДТГ | 8.4 | 10.0 | 1.6 | 118.5 | 24.7 | 27.5 | 2.8 | 111.3 | 33.1 | 37.4 | 4.3 | 113.1 |
| ЕБС | 5.5 | 4.1 | -1.4 | 74.7 | | | | 0.0 | 5.5 | 4.1 | -1.4 | 74.7 |
| Соёлын төв | 9.3 | 5.2 | -4.1 | 56.1 | | | 0.0 | 0.0 | 9.3 | 5.2 | -4.1 | 56.1 |
| СХС | 1499.0 | 1336.0 | -163.0 | 89.1 | | 10.6 | 10.6 | 0.0 | 1499.0 | 1346.6 | -152.4 | 89.8 |
| ОНХС | 64.0 | 64.2 | 0.2 | 100.3 | 476.6 | 431.3 | -45.3 | 90.5 | 540.6 | 495.5 | -45.2 | 91.6 |
| аймгийн ОНБ | 18.0 | 18.4 | 0.4 | 102.0 | 99.0 | 80.4 | -18.6 | 81.2 | 117.0 | 98.8 | -18.2 | 84.4 |
| Аймгийн ТЗШБ | 20.0 | 20.5 | 0.4 | 102.3 | | | 0.0 | 0.0 | 20.0 | 20.5 | 0.4 | 102.3 |
| Аймгийн ОНХС | | | 0.0 | 0.0 | 1309.2 | 563.6 | -745.6 | 43.0 | 1309.2 | 563.6 | -745.6 | 43.0 |
| Өрхийн эмнэлэг | | 25.8 | 25.8 | 0.0 | | | 0.0 | 0.0 | 0.0 | 25.8 | 25.8 | 0.0 |
| ДҮН | 1624.3 | 1484.1 | -140.2 | 91.4 | 1909.5 | 1113.4 | -796.2 | 58.3 | 3533.8 | 2597.5 | -936.3 | 73.5 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

24. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.11.27-ний өдрийн 117 дугаар тогтоолоор уул уурхайн ашиглалтын чиглэлээр 2020 онд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдээс орон нутагт үзүүлэх хандив дэмжлэгийн доод хэмжээг тогтоож, хандивын 70 хувь буюу 1200.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 30 хувийг үйл ажиллагаа явуулж

байгаа сумын ОНХС-л оруулахаар баталснаас 6 аж ахуйн нэгжээс 605.4 (50.5%) сая төгрөг аймгийн ОНХС-д орж, хандивын орлогын төлөвлөгөө 595.1 сая төгрөгөөр тасарсан байна.

25. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан ХХОАТ-ын буцаан олголтод 2020 онд анх 800.0 сая төгрөг олгохоор батлагдаж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.09.18-ний өдрийн 21/03 дугаар тогтоолоор 347.6 сая төгрөгөөр бууруулж, 452.4 сая төгрөгөөр батлагджээ.

Аймгийн Татварын хэлтсийн даргын 2012.04.22-ний өдрийн А/23 дугаар тушаалаар 998 татвар төлөгчид 451.4 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 452.7 сая төгрөг олгож, батлагдсан зардлаас 1.3 сая төгрөгийг илүү олгосон нь өмнөх онд олгогдоогүй татварын буцаан олголтыг олгосонтой холбоотой байна.

26. ТБОНӨХ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор өмнөх онд 71.9 сая төгрөгийг оруулсан бол 2020 онд тус орлогыг Сангийн яамнаас 50.0 сая төгрөг батласныг аймгийн ИТХ-аар анх 51.0 сая төгрөгөөр баталж, 2020 оны 09 дүгээр сард төсөвт оруулсан тодотголоор 49.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 100.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 269.1 (269.1%) сая төгрөг оруулжээ.

Тайлант онд 13 автомашин худалдан борлуулахаас 11, 7 үл хөдлөх хөрөнгө борлуулахаас 3 үл хөдлөх хөрөнгийг борлуулж, дуудлага худалдааны орлогоор 39.8 сая, дуудлага худалдааны хураамжийн орлогоор 3.4 сая төгрөгийг оруулж, төлөвлөсөн орлого тасарсан боловч акталсан хөрөнгө борлуулсны орлогоор 25.9 сая, 5 дугаар сургуулийн уурын зуух барих эрхийн дуудлага худалдааны орлогоор 200.0 сая төгрөг орсноор тус орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

27. Сумдын 6 соёлын төв үйл ажиллагааны орлогоор 2019 онд 12.0 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 7.4 сая төгрөгийн орлого оруулсан бол тайлант онд 6 сум 9.3 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс Хүрээмарал сумаас бусад сумд 5.2 (56.1%) сая төгрөгийн орлого оруулж ажилласан нь дэлхий нийтэд гарсан цар тахлын улмаас соёлын арга хэмжээ явагдаагүйн нөлөөлсөн байна.

*Хүснэгт 9 . Сумын соёлын төвийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/*

| № | Сумын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4=3-2 | 5=3/2 |
| 1 | Баянговь | 0.2 | 0.2 | 0.0 | 100.0 |
| 2 | Заг | 0.0 | 0.1 | 0.1 | **0.0** |
| 3 | Баацагаан | 2.6 | 1.3 | -1.3 | 48.6 |
| 4 | Бөмбөгөр | 1.5 | 0.9 | -0.6 | **61.9** |
| 5 | Хүрээмарал | 1.0 | 0.0 | -1.0 | 0.0 |
| 6 | Шинэжинст | 1.0 | 1.8 | 0.8 | 180.0 |
| 7 | Баянцагаан | 3.0 | 0.9 | -2.1 | **29.2** |
| | ДҮН | 9.3 | 5.2 | 4.1 | 56.1 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

28. Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн орлогоор 1499.0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 89.8 хувь буюу 1346.6 сая төгрөг оруулсан ба Заг, Баянхонгор, Баянлиг, Бөмбөгөр, Баянбулаг сумд сум

хөгжүүлэх сангийн орлогыг бүрэн оруулсан бол Бууцагаан сум төлөвлөсөн орлогын төлөвлөгөөг 12.9%, Баацагаан 44.2%, Жаргалант 45.1%-тай оруулж, хугацаа хэтэрсэн зээл өндөртэй байна.

*Хүснэгт 10 . Сумын сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

| № | Сумын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | № | Сумын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4=3-2 | 5=3/2 | А | 1 | 2 | 3 | 4=3-2 | 5=3/2 |
| 1 | Галуут | 97.6 | 49.29 | -48.3 | 50.5 | 11 | Заг | 21.0 | 58.08 | 37.1 | **276.6** |
| 2 | Баяновоо | 60.0 | 28.63 | -31.4 | 47.7 | 12 | Баацагаан | 123.5 | 54.59 | -68.9 | 44.2 |
| 3 | Эрдэнэцогт | 63.3 | 49.79 | -13.5 | 78.6 | 13 | Бөмбөгөр | 53.0 | 70.40 | 17.4 | **132.8** |
| 4 | Бууцагаан | 100.0 | 12.94 | -87.1 | 12.9 | 14 | Өлзийт | 50.8 | 50.17 | -0.7 | 98.7 |
| 5 | Жинст | 95.5 | 57.54 | -37.9 | 60.3 | 15 | Хүрээмарал | 65.3 | 46.46 | -18.8 | 71.2 |
| 6 | Богд | 81.6 | 71.76 | -9.9 | 87.9 | 16 | Баянбулаг | 70.0 | 74.51 | 4.5 | **106.4** |
| 7 | Баянлиг | 36.0 | 49.90 | 13.9 | **138.7** | 17 | Шинэжинст | 32.0 | 28.53 | -3.4 | 89.2 |
| 8 | Баянговь | 25.0 | 24.73 | -0.3 | 98.9 | 18 | Баянцагаан | 55.0 | 84.85 | 29.8 | **154.3** |
| 9 | Гурванбулаг | 95.4 | 55.99 | -39.4 | 58.7 | 19 | Баянөндөр | 72.2 | 65.56 | -6.6 | 90.8 |
| 10 | Жаргалант | 124.1 | 55.92 | -68.1 | 45.1 | 20 | Баянхонгор | 177.8 | 356.96 | 179.2 | **200.8** |
| **Төлөвлөгөө 1499.0 сая төгрөг, гүйцэтгэл 1346.6 сая төгрөг Биелэлт 89.8%** | | | | | | | | | | | |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

29. Сумдын ИТХ-аар ЗДТГ-ын өөрийн орлогыг баталж, сумдын ЗДТГ-ын дүнгээр нийт 34.1 сая төгрөгийг оруулахаар 37.5 (109.8%) сая төгрөг оруулж, 9 сумын ЗДТГ тайлант оны орлогын төлөвлөгөөг биелүүлж, 11 сумын ЗДТГ орлогыг бүрэн оруулаагүй байна.

*Хүснэгт 11 . Сумын ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

| № | Сумын нэр | Өөрийн орлого | | | | № | Сумын нэр | Өөрийн орлого | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Галуут | 1.00 | 0.50 | (0.50) | 50.0 | 12 | Баацагаан | 1.00 | 0.18 | (0.83) | 17.5 |
| 2 | Баяновоо | 1.00 | 0.66 | (0.34) | 66.0 | 13 | Бөмбөгөр | 1.00 | 0.57 | (0.43) | 57.0 |
| 3 | Эрдэнэцогт | 2.00 | 2.00 | - | 100.0 | 14 | Өлзийт | 4.00 | 4.10 | 0.10 | 102.5 |
| 4 | Бууцагаан | 1.00 | 1.00 | - | 100.0 | 15 | Хүрээмарал | 1.00 | 0.84 | (0.16) | 84.0 |
| 5 | Жинст | 1.00 | 0.70 | (0.30) | 70.0 | 16 | Баянбулаг | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 6 | Богд | 1.00 | 0.98 | (0.02) | 98.5 | 17 | Шинэжинст | 1.20 | 0.40 | (0.80) | 33.6 |
| 7 | Баянлиг | 1.00 | 4.20 | 3.20 | 420.0 | 18 | Баянцагаан | 1.00 | 0.51 | (0.49) | 50.8 |
| 8 | Баянговь | 1.00 | 1.19 | 0.19 | 119.0 | 19 | Баянөндөр | 1.00 | 1.51 | 0.51 | 151.3 |
| 9 | Гурванбулаг | 1.00 | 0.75 | (0.25) | 75.4 | 20 | Шаргалжуут тосгоны ажлын алба | 8.40 | 8.40 | - | 100.0 |
| 10 | Жаргалант | 1.00 | 1.86 | 0.86 | 185.9 | 21 | Баянхонгор | 2.50 | 5.79 | 3.29 | 231.6 |
| 11 | Заг | 1.00 | 0.30 | (0.70) | 30.0 | | ДҮН | 34.10 | 37.45 | 3.35 | 109.8 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

## БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ТӨРИЙН САНГИЙН ДОТООД ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛДАГ ЗӨРЧИЛ БҮРЭН АРИЛАХГҮЙ БАЙНА.

### 2.1. Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн Piscal программд төсөвт байгууллагуудын зарцуулах эрхийг зөрүүтэй татаж, төсвийн төлөвлөлтийг гарсан зардлаар тайлагнаснаас төсвийн төлөвлөлтийн үндэслэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

30. Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны урсгал зардлыг өмнөх оноос 17570.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 87523.2 сая, хөрөнгийн зардлыг 2765.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 9349.9 сая, нийт 96873.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.09.18-ний өдрийн 21/03 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн 2020 оны нийт төсвийг 2635.0 сая төгрөгөөр бууруулж, 94238.1

сая төгрөгөөр баталснаас урсгал зардлыг 2014.3 сая, хөрөнгийн зардлыг 620.7 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

| № | Зардлын төрөл | Өмнөх оны гүйцэтгэл | Анхны батлагдсан төсөв | Тодотгосон төсөв | Төсөвт орсон өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Урсгал зардал | 69953.1 | 87523.2 | 85508.9 | -2014.3 |
| 2 | хөрөнгийн зардал | 6584.2 | 9349.9 | 8729.2 | -620.7 |
| | Нийт зардал | 76537.3 | 96873.1 | 94238.1 | -2635.0 |

Төсвийн нийт зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 20335.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь дараах шалтгаантай байна.

- Төрийн албан хаагчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан 8 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон;
- Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын дагуу төрийн үйлчилгээний албан хаагч нь төрийн захиргааны албан хаагчийн нэгэн адил төрд ажилласан хугацаагаараа тооцуулж цалингийн нэмэгдэл авахаар болсон;
- Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын дагуу төрийн үйлчилгээний албан хаагчдад тэтгэвэрт гарахад нь 36 хүртэл сарын нэг удаагийн тэтгэмжийг 2020 оноос эхлэн олгож эхэлсэн;
- Цэцэрлэгийн хүүхдийн хоол, үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын тогтоолоор 50 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн;
- Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор сумын санхүүгийн албаны орон тоог 4 байхаар тогтоосны дагуу сумдын Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоонд 1 нягтлан бодогчийн орон тоог нэмсэн;
- Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнд ногдох нормативаар олгох санхүүжилт нь дунджаар 15.0 мянган төгрөг байсан бол 30.0 мянган төгрөг болж нэмэгдсэн;
- Байгууллагуудаас авсан судалгаан дээр үндэслэн байгууллагуудын шаардлагатай тоног төхөөрөмж хүүхдийн цэцэрлэгийн ангиудын дэвсгэр, хөгжмийн зэмсэг, багш нарын компьютер, принтер, тоглоом, сургуулийн хөгжмийн зэмсэг, бүрэн дунд сургуулиудын байгалийн ухааны кабинет тохижуулах зардал, соёлын төвүүдэд цахим ном сүлжээнд холбогдох интернетэд холбогдох зардал зэргийг төсөвт тусгаж өгсөн;
- Улсын Их хурлаар 2017.11.10-ний өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль нь 2020.01.01 өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор ажил олгогчоос төлөх НДШ-ийн хувь хэмжээг 1 хувиар нэмэгдүүлэн 13,5% байхаар тооцсон;
- Аймгийн төвийн дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын 1м3 дулааны үнэ тарифыг 2020.01.01-ний өдрөөс 8 хувиар нэмэгдүүлсэн зэрэгтэй тус тус холбоотой байна.

31. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд 2020.08.28-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Баянхонгор аймагт улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр анх батлагдсан 50938.5 сая төгрөгийг 1876.7 сая төгрөгөөр бууруулсныг аймгийн ИТХ-ын хуралдаанаар бууруулан баталжээ.

*Хүснэгт 12. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөвт орсон өөрчлөлт*

| Байгууллага | Тоо | Анх батлагдсан төсөв | Тодотгосон төсөв | Зөрүү |
|---|---|---|---|---|
| Ерөнхий боловсролын сургууль | 29 | 28,972.0 | 27,818.5 | 1,153.5 |
| Сургуулийн өмнөх боловсрол | 36 | 12,793.2 | 12,242.7 | 550.5 |
| Эрүүл мэндийн төв | 17 | 6,155.4 | 6,155.4 | - |
| Өрхийн эмт | 5 | 835.6 | 835.6 | - |
| Хувийн цэцэрлэг | 7 | 790.5 | 604.5 | 186.0 |
| Хувийн сургууль | 2 | 185.1 | 198.4 | (13.3) |
| ГБХЗХГ | 1 | 634.5 | 634.5 | - |
| ГХБХБГ | 1 | 552.3 | 552.3 | - |
| Насан туршийн боловсрол | 1 | 20.0 | 20.0 | - |
| **Нийт** | 99 | 50,938.5 | 49,061.8 | 1876.7 |

*Эх сурвалж: МУ-ын Төсвийн тухай хууль, аймгийн ИТХ-ын тогтоол*

32. Дээрх хуваарилсан тусгай зориулалтын шилжүүлгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 6990.9 сая, ерөнхий боловсролын үйлчилгээнд 28036.9 сая, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 12847.2 сая, газрын харилцаа кадастрын үйлчилгээнд 552.3 сая, хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээнд 634.5 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.




33. Баянхонгор аймгийн төсвийг 2635.0 сая төгрөгийг бууруулан тодотгохдоо дэлхий нийтийг хамарсан халдварт Ковид-19 цар тахал гарч, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжихтэй холбоотой аймгийн ЗДТГ-т 1010.7 сая, сумдын ЗДТГ-дад 2132.4 сая төгрөгийг хуваарилсныг бусад төсөвт байгууллагуудын төсвөөс хасаж тодотгосон байна.

*Хүснэгт 13 .Байгууллагын төсөвт орсон өөрчлөлт /сая төгрөгөөр/*

| Зарлагын төрөл | Тоо | Батлагдсан төсөв | Тодотгосон төсөв | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| Аймгийн 2020 оны төсвийн жилд зарцуулах зарлагын дүн | 207 | 96,873.1 | 94,238.1 | (2,635.0) |
| Аймгийн ИТХ | 1 | 659.0 | 633.3 | (25.7) |
| Сумдын ИТХ | 20 | 1,712.8 | 1,714.9 | 2.1 |
| Сумдын ЗДТГ | 20 | 9,185.4 | 9,318.9 | 133.5 |
| Сумдын Орон нутгийн хөгжлийн сан | 20 | 3,969.2 | 3,882.8 | (86.4) |
| Сумдын Сум хөгжүүлэх сан | 20 | 2,608.8 | 2,486.5 | (122.2) |
| Ерөнхий боловсролын сургууль | 29 | 31,486.4 | 30,607.3 | (879.0) |
| Цэцэрлэг | 36 | 14,414.9 | 12,496.5 | (1,918.4) |
| Сумдын эрүүл мэндийн төв | 17 | 7,240.5 | 7,216.6 | (23.9) |
| Сумдын соёлын төв | 19 | 2,042.7 | 1,991.4 | (51.3) |
| Аймгийн Засаг даргын тамгын газар | 1 | 2,577.5 | 3,588.2 | 1,010.7 |
| Асрамжийн газар | 1 | 127.5 | 142.7 | 15.2 |
| Засаг дарга /ангилагдаагүй зардал/ | 1 | 3,621.5 | 3,308.0 | (313.5) |
| Аймгийн ахмадын байгууллага | | 118.1 | 118.1 | - |
| Хотын нийтийн хүн тээвэр | | 48.0 | 16.0 | (32.0) |
| Мал эмнэлгийн үйлчилгээний хөлс | | 709.3 | 709.3 | - |
| Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 1 | 994.3 | 923.7 | (70.6) |
| Замын сан | 1 | 720.0 | 740.7 | 20.7 |
| Ойн анги | 1 | 78.0 | 69.8 | (8.2) |
| Халамжийн сан | 1 | 151.5 | 151.5 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Түүх угсаатны зүй, байгалийн музей | 1 | 327.6 | 319.8 | (7.8) |
| Нийтийн номын сан | 1 | 177.2 | 174.2 | (3.0) |
| Биеийн тамир спортын газар | 1 | 797.0 | 770.2 | (26.8) |
| Хүүхдийн Тэмүжин театр | 1 | 444.5 | 434.7 | (9.8) |
| Хөгжимт драмын театр | 1 | 1,054.1 | 1,021.1 | (33.0) |
| Хүүхэд, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар | 1 | 649.5 | 648.5 | (1.0) |
| Санхүүгийн хяналт, аудитын алба | 1 | 165.8 | 156.9 | (8.9) |
| Орон нутгийн өмчийн газар | 1 | 193.0 | 186.0 | (6.9) |
| Хот тохижилт, үйлчилгээний газар | 1 | 668.6 | 640.6 | (28.0) |
| Баянхонгор аймаг Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба | 1 | 67.5 | 67.3 | (0.3) |
| Хувийн сургууль /5 дугаар сургуулийн тогтмол зардал/ | 1 | 2,252.7 | - | (2,252.7) |
| Хувийн цэцэрлэгүүд | | 790.5 | 476.1 | (314.3) |
| Хувийн сургууль | | - | 312.5 | 312.5 |
| Өрхийн эмнэлэг | 4 | 835.6 | 835.6 | 0.0 |
| Аймгийн ОНХС | 1 | 5,380.7 | 4,846.3 | (534.4) |
| Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | 1 | 583.6 | 581.1 | (2.5) |
| Насан туршийн боловсрол | 1 | 20.0 | 30.0 | 10.0 |
| Цэцэрлэгийн ТЗШ-ийн хэмнэлт | | - | 1,404.3 | 1,404.3 |
| Сургуулийн ТЗШ-ийн хэмнэлт | | - | 1,216.5 | 1,216.5 |

*сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд*

34. Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн ашиглалтын зардалд анх 2056.1 сая төгрөгийг баталж, үйл ажиллагаа явуулж эхлээгүйгээс оны дундуур тус сургуульд хуваарилсан зардлыг бусад төсөвт байгууллагуудад хуваарилж байгаа зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.

35. Төсвийн шууд захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар сумдын 17 Эрүүл мэндийн төв системийн дээд байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний статистик тоон мэдээллийг ЭМЯ-д хүргүүлж түүнд үндэслэн төсвийн төслийг боловсруулдаг тул байгууллагаар төсвийн төсөл боловсруулдаггүй гэсэн тайлбарыг аймгийн ЭМГ-ын төсвийн мэргэжилтэн өгсөн бөгөөд тухайн байгууллага дээр төсвийн төсөл нэгтгэсэн дүнгээр боловсруулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1[10] дэх заалттай нийцэхгүй тул аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргад төсвийн төслийг авч нэгтгэж байх зөвлөмжийг хүргүүллээ.

## 2.2. Төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналт сулаас аудитаар төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4638.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

36. Аймгийн ТЕЗ-ийн гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 18764.2 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 49061.8 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 5936.9 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 457.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, орон нутгийн орлогоос 11573.0 сая төгрөгийг зарцуулж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 2597.5 сая төгрөгийн орлого оруулж, урьд оны үлдэгдлээс 1383.0 сая төгрөг авч, оны эцэст орон нутгийн байгууллагууд 939.9 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 1524.7 сая төгрөгийг

[10] *төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх;*

буцаан төвлөрүүлж, нийт 87309.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

*Хүснэгт 14. Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан / сая төгрөг/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 79,839.16 | 76,537.23 | 94,238.11 | 87,309.50 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 72,046.11 | 69,952.96 | 85,508.93 | 80,417.79 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 68,920.07 | 66,868.68 | 82,151.19 | 77,492.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 37,635.00 | 37,501.49 | 44,472.38 | 43,806.59 |
| 210101 | Үндсэн цалин | 29,975.37 | 30,039.42 | 33,319.23 | 33,042.20 |
| 210102 | Нэмэгдэл | 4,141.06 | 4,127.27 | 6,363.02 | 6,476.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 212.00 | 195.15 | 240.16 | 217.99 |
| 210104 | Урамшуулал | 2,603.90 | 2,486.63 | 3,792.33 | 3,463.82 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 702.67 | 653.02 | 757.64 | 606.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,820.24 | 4,767.93 | 5,830.27 | 5,637.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,384.16 | 3,378.99 | 4,044.95 | 3,960.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 358.77 | 350.89 | 446.19 | 425.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 287.42 | 275.36 | 355.83 | 328.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 71.72 | 68.44 | 90.47 | 81.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 718.16 | 694.25 | 892.83 | 841.97 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,766.26 | 7,660.59 | 8,526.28 | 8,142.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 529.99 | 545.01 | 543.41 | 482.96 |
| 210302 | Түлш, халаалт | 6,711.44 | 6,612.38 | 7,464.40 | 7,162.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 442.10 | 423.73 | 439.86 | 418.25 |
| 210304 | Байрны түрээс | 82.73 | 79.46 | 78.60 | 78.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,937.50 | 1,880.56 | 2,257.60 | 2,172.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 234.83 | 255.08 | 271.43 | 267.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,034.56 | 987.22 | 1,174.25 | 1,131.88 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 231.73 | 196.56 | 228.64 | 208.46 |
| 210404 | Ном, хэвлэл | 118.92 | 108.21 | 137.75 | 130.12 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 57.42 | 54.66 | 161.01 | 157.05 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 260.05 | 278.84 | 284.52 | 278.23 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,219.67 | 3,145.18 | 5,267.09 | 4,043.47 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 482.11 | 447.64 | 393.77 | 364.59 |
| 210502 | Хоол, хүнс | 2,498.53 | 2,469.31 | 4,355.09 | 3,189.94 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 239.03 | 228.23 | 518.23 | 488.95 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,679.73 | 2,641.93 | 2,097.31 | 1,920.41 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 343.34 | 350.31 | 723.44 | 647.44 |
| 210602 | Тавилга | 860.07 | 827.71 | 277.12 | 263.64 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 15.56 | 17.11 | 6.06 | 5.08 |
| 210604 | Урсгал засвар | 1,460.75 | 1,446.80 | 1,090.70 | 1,004.25 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 591.14 | 574.92 | 388.72 | 313.78 |
| 210701 | Гадаад албан томилолт | 78.91 | 77.73 | 19.30 | 18.30 |
| 210702 | Дотоод албан томилолт | 388.76 | 359.71 | 322.66 | 249.48 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 123.47 | 137.48 | 46.76 | 45.99 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,290.15 | 3,881.67 | 5,074.39 | 3,727.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,189.22 | 3,782.78 | 4,941.91 | 3,598.96 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 26.65 | 26.58 | 40.52 | 38.88 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13.16 | 12.93 | 15.26 | 14.88 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 6.17 | 5.80 | 6.15 | 5.54 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 2.54 | 2.24 | 2.51 | 2.05 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 48.17 | 47.40 | 57.14 | 56.66 |
| 210807 | Газрын төлбөр | 3.13 | 2.94 | 10.19 | 9.48 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.44 | 0.36 | 0.57 | 0.40 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 0.66 | 0.66 | 0.14 | 0.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,980.39 | 4,814.40 | 8,237.16 | 7,728.45 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,097.22 | 3,933.54 | 6,762.70 | 6,263.16 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 883.17 | 880.86 | 1,474.46 | 1,465.29 |
| **212** | **ТАТААС** | 526.60 | 531.54 | 851.56 | 835.56 |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 526.60 | 531.54 | 851.56 | 835.56 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 526.60 | 531.54 | 851.56 | 835.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,599.44 | 2,552.74 | 2,506.18 | 2,089.78 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 931.91 | 909.71 | 740.66 | 728.52 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 931.91 | 909.71 | 740.66 | 728.52 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,667.53 | 1,643.03 | 1,765.52 | 1,361.25 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 246.14 | 245.84 | 151.45 | 150.77 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 44.87 | 43.86 | 128.50 | 128.44 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 796.40 | 783.55 | 772.10 | 451.07 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 228.43 | 222.69 | 402.37 | 341.14 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 351.69 | 347.08 | 311.09 | 289.82 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,793.05** | **6,584.27** | **8,729.18** | **6,891.72** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,793.05 | 6,584.27 | 8,729.18 | 6,891.72 |
| 220001 | Барилга байгууламж | 7,793.05 | 6,584.27 | 8,729.18 | 6,891.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 79,839.16 | 75,920.45 | 94,238.11 | 87,489.88 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 40,768.31 | 40,590.79 | 49,061.84 | 46,700.51 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 40,768.31 | 40,590.79 | 49,061.84 | 46,700.51 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 32,254.81 | 33,051.68 | 39,378.40 | 37,734.26 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 25,768.93 | 26,759.30 | 32,952.57 | 31,797.35 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 6,485.88 | 6,292.37 | 6,425.83 | 5,936.91 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 486.42 | 375.93 | 486.42 | 457.61 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 486.42 | 375.93 | 486.42 | 457.61 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 6,329.62 | 1,902.04 | 5,311.46 | 2,597.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,024.85 | 1,356.55 | 1,624.27 | 1,484.13 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 732.43 | 545.49 | 1,910.52 | 1,113.37 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 3,572.34 | - | 1,776.67 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **2,593.86** | - | 1,977.08 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **1,977.08** | - | 2,157.46 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 158.00 | 158.00 | 158.00 | 158.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 158 | 158 | 158 | 158.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 3811.00 | 3826.00 | 3839.00 | 3,879.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 312 | 312 | 311 | 299.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2,257.00 | 2,279.00 | 2,422.00 | 2,470.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1,062.00 | 1,051.00 | 966 | 969.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 180 | 184 | 140 | 141.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 22309.00 | 22548.00 | 23446.00 | 22,883.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 16785.00 | 17133.00 | 17696.00 | 17,356.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 16,785.00 | 17,133.00 | 17,696.00 | 17,356.00 |
| 630002 | Хувийн ЕБС | | | 0 | - |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 5524.00 | 5415.00 | 5750.00 | 5,527.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 5,524.00 | 5,415.00 | 5,750.00 | 5,527.00 |
| 631002 | Хувийн өмчит СӨБ байгууллага | | | 0 | - |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | 0.00 | 39190.00 | 0.00 | 32,915.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | 5,658.00 | 0 | 3,303.00 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо | | 33,532.00 | 0 | 29,327.00 |
| 640003 | Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо | | | 0 | 285.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **3811.0** | **3826.0** | **3839.0** | **3,879.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 337 | 338 | 346 | 345.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 3 | 4 | 4 | 4.00 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 0 | 0 | 0 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 1,514.00 | 1,522.00 | 1,649.00 | 1,654.00 |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | 0 | 0 | 0 | - |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 143 | 153 | 126 | 124.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 0 | 5 | 0 | - |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 287 | 282 | 287 | 285.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1,180.00 | 1,170.00 | 1,126.00 | 1,166.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 179 | 184 | 131 | 131.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 168 | 168 | 170 | 170.00 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлан*

37. Тайлант онд улсын төсвөөс олгосон 49061.8 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийг яамдаар нь авч үзвэл нийт зардлын 83.3 хувийг БСШУС, 14.2 хувийг ЭМС, 1.3 хувийг ХАХНХС, 1.1 хувийг БХБС-ын багцын байгууллагуудын зардал ээлж байгаа ба батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, батлагдсан зардлын 95.2 хувийг буюу 46700.5 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 2361.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 15. Тусгай зориулалтын шилжүүлгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, яамдаар /сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Нийт дүн | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|
| | | БСШУС-ын сайд | ХАХНХ- ын сайд | ЭМС-ын сайд | БХБ-ын сайд |
| Батлагдсан төсөв | 49,061.8 | 40,884.1 | 634.5 | 6,990.9 | 552.3 |
| Олгосон урсгал санхүүжилт | 49,061.8 | 40,884.1 | 634.5 | 6,990.9 | 552.3 |
| Зардлын гүйцэтгэл | 46,700.5 | 38,604.1 | 632.3 | 6,928.1 | 536.0 |
| Зардлын гүйцэтгэл /хувиар/ | 95.2% | 94.4% | 99.6% | 99.1% | 97.1% |
| Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн | 2,361.3 | 2,280.0 | 2.2 | 62.8 | 16.3 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

38. Аймгийн ТЕЗ-ийн нийт зардлыг өмнөх онуудтай харьцуулахад зардал инфляцийн түвшин нэмэгдсэнээс шалтгаалж жил бүр зардлын дүн өссөн байна.

*Хүснэгт 16. Зардлын харьцуулсан судалгаа /сая төгрөгөөр/*

| Он | Зардлын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 2018 | Урсгал | 66,048.7 | 64,381.7 | 1,667.0 |
| | Хөрөнгийн | 7,869.8 | 5,126.5 | 2,743.3 |
| 2019 | Урсгал | 72,046.1 | 69,953.1 | 2,093.0 |
| | Хөрөнгийн | 7,793.1 | 6,584.3 | 1,208.8 |
| 2020 | Урсгал | 85,508.9 | 80,417.8 | 5,091.1 |
| | Хөрөнгийн | 8,729.2 | 6,891.7 | 1,837.5 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

39. Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 10772.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 87309.5 сая төгрөгийг зарцуулснаас 92.1 хувь буюу 80417.8 сая төгрөгийг урсгал зардалд, 7.9 хувь буюу 6891.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулжээ.

*Хүснэгт 17. Зардлын гүйцэтгэл /сая төгрөг/*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны гүйцэтгэл | Эзлэх хувь | Өмнөх оноос өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 76,537.1 | 87,309.5 | 100.0 | 10,772.4 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **69,952.8** | **80,417.8** | **92.1** | **10,465.0** |
| **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **66,868.6** | **77,492.4** | **88.8** | **10,623.8** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 37,501.4 | 43,806.6 | **50.2** | 6,305.2 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,767.9 | 5,637.3 | **6.5** | 869.4 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,660.6 | 8,142.4 | **9.3** | 481.8 |
| Хангамж, бараа материалын зардал | 1,880.5 | 2,173.0 | **2.5** | 292.5 |
| Нормативт зардал | 3,145.2 | 4,043.5 | **4.6** | 898.3 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2,641.9 | 1,920.4 | **2.2** | (721.5) |
| Томилолт, зочны зардал | 574.9 | 313.8 | **0.4** | (261.1) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,881.8 | 3,727.0 | **4.3** | (154.8) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,814.4 | 7,728.4 | **8.9** | 2,914.0 |
| **ТАТААС** | **531.5** | **835.6** | **1.0** | 304.1 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,552.7** | **2,089.8** | **2.4** | (462.9) |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,584.3** | **6,891.7** | **7.9** | 307.4 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

40. Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрснийг цаашид анхаарч, дүн шинжилгээ хийж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

**Цалингийн зардал:**

Цалингийн зардлыг анх 44508.9 сая төгрөгөөр баталсныг оны дундуур төсөвт хийсэн төсөвт зохицуулалтаар 36.5 сая төгрөгөөр хасаж, 44472.4 сая төгрөгөөр батлан, гүйцэтгэлээр 43806.6 сая төгрөгийг олгож, цалингийн зардлыг 665.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

*Хүснэгт 18 . Цалингийн зардал /сая төгрөгөөр/*

| № | Салбарын нэр | Анх батлагдсан төсөв | Зохицуулалт хийсэн дүн | Оны эцсийн төсөв | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Орон нутаг | 11,663.1 | 0.0 | 11663.1 | 11477.2 | 185.9 |
| 2 | Боловсрол | 28,028.3 | -77.9 | 27950.3 | 27491.8 | 458.5 |
| 3 | Эрүүл мэнд | 4,817.5 | 41.5 | 4859.0 | 4837.6 | 21.4 |
| | Дүн | 44,508.9 | (36.5) | 44,472.4 | 43806.6 | 665.8 |

*Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн төсвийн мэргэжилтнээс ирүүлсэн судалгаа*

Дээрх хүснэгтээс харахад орон нутгийн төсөвт байгууллагууд цалингийн зардлыг 185.9 сая, боловсролын байгууллагууд 458.5 сая, эрүүл мэндийн байгууллагууд 21.4 сая төгрөгөөр хэмнэсэн нь дараах шалтгаантай байна.

- ✓ *Сумдын Эрүүл мэндийн төвүүдээс Бууцагаан сум 3, Баян-Овоо сум 1, Шаргалжуут тосгон 1, Хүрээмарал сум 2, Баянбулаг сум 2 орон тоо дутуу ажилласан;*
- ✓ *Боловсролын салбарын хувьд Ковид-19 цар тахалтай холбоотой танхимаар хичээллээгүйгээс багш нарын анги даалт, илүү цагийн цагийн нэмэгдэл хөлс олгоогүй;*
- ✓ *Орон нутгийн төсөвт байгууллагуудаас Баянхонгор сумын ЗДТГ 19.2 сая, Баянцагааны ЗДТГ 11.3 сая, Байгаль орчны алба 12.7 сая, Биеийн тамир спортын газар 12.2 сая, Баянхонгор аймгийн ЗДТГ 35.8 сая төгрөг хэмнэсэн нь голлох нөлөө үзүүлж байгаа бөгөөд тус байгууллагууд орон тоо дутуу ажилласан, хүүхэд харах чөлөөтэй байгаа ажилтныг оронд хүн авч ажиллуулаагүй, зарим албан тушаалтныг оны дундуур томилсон зэрэг шалтгаантай байна.*

41. Төсвийн шууд захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан дараах зөрчлүүд илэрсэн байна.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Биеийн тамир, спортын газар, 11-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг, Гурванбулаг сумын сургууль, Заг сумын Ерөнхий боловсролын сургууль, Байгал, орчин аялал жуулчлалын газар, Эрдэнэмандал ахлах сургууль, Баянхонгор сумын ЗДТГ зэрэг төсөвт байгууллагууд шүүхийн шийдвэрээр 43.4 сая төгрөгийг цалингийн сангаас олгосон;*
- *Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Нийтийн номын сан, 11-р дүгээр цэцэрлэгүүд цалингийн зардлаас 4.9 сая төгрөгийн түлш халаалтын хөнгөлөлт олгосон;*
- *Баянхонгор сумын 5-р цэцэрлэг, аймгийн ЗДТГ-ын төсвийн захирагч нар хууль тогтоомжийг зөрчиж, өөртөө болон байгууллагын албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтөд 4.7 сая төгрөг олгосон;*
- *Дэлхий нийтэд гарсан Ковид-19 цар тахалтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдсан Наранмандал, Энхбүрд, Оточ номгон өрхийн эмнэлгүүд 50.7 сая төгрөгийн НДШ-ийн хөнгөлөлтийг эдэлж, хэмнэгдсэн зардлыг хөрөнгө худалдан авах, үйл ажиллагааны бусад зардалд зориулалт бусаар зарцуулсан;*
- *Баацагаан сумын сургууль, 6-р цэцэрлэг цалингийн сангаас 2.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон;*
- *Баянлиг сургууль, Баянхонгор аймгийн ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Хөгжимт драмын театр 13,10,11,3 дугаар цэцэрлэгүүд, Баян-Өйт сургууль, Бууцагаан сумын ЗДТГ, Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль, Эрдэнэцогт Ерөнхий боловсролын сургуулиуд 10.7 сая төгрөгийн цалин, хөлс, нэмэгдэл урамшууллыг илүү бодож ажиллагсдад олгосон;*
- *"Цэвэр хот" ОНӨТҮГ 2.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант онд суутгаж аваагүй;*
- *Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв, Эрдэнэцогт сумын цэцэрлэг тайлант хугацаанд гүйлгээ хийгээгүй 11.7 сая төгрөгийн НДШ-ийн өглөг үүсгэж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан;*
- *Санхүүгийн хяналт, аудитын алба, "Цэвэр хот" ОНӨҮГ 11.3 сая төгрөгийн цалингийн зардлыг хоол, унааны хөнгөлөлтөд гүйлгэн зарцуулсан;*
- *Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүүжин театр, 11,3,6 дугаар цэцэрлэг, Заг сумын Эрүүл мэндийн төвүүд сахилгын шийтгэлтэй албан хаагчдад 5.4 сая төгрөгийн урамшуулал олгосон;*
- *Галуут сумын ЗДТГ 0.7 сая төгрөгийн төлбөрийн актыг цалингийн сангаас олгосон;*
- *10 дугаар цэцэрлэг, Баян-Өйт сургууль, Бөмбөгөр сумын сургуулиуд 20.9 сая төгрөгийг НДШ-ийн зардлаас гүйлгэн цалингийн зардалд олгосон зэрэг зөрчил илэрчээ.*

Эрүүл мэндийн сайдын 2020.08.10-ны өдрийн А/392 дугаар тушаал, 2020.08.10-ны өдрийн 1а/3345 дугаар албан бичигт эрүүл мэндийн сайдын багцын байгууллагуудын 2020 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж ажлын үр дүнгээр хангалттай үнэлгээ авсан байгууллагуудын дарга, ахлах нягтлан бодогч, эдийн засагч, нярав нарт батлагдсан төсөвт багтаан урамшуулал олгох шийдвэрийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, ахлах нягтлан бодогч, төсвийн мэргэжилтэн, нярав нарт 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгосон байна.

Мөн дээрх тушаалыг үндэслэн Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга тушаал гаргаж, аймгийн Зооноз өвчин судлалын төвийн дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга, ерөнхий нягтлан бодогч нарт урамшуулал олгосны зэрэгцээ цар тахалтай холбоотой 2020 оны 1, 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал болон 2020 оны

хагас жилийн ажил дүгнэсэн урамшуулал олгож төсвөөс урамшууллуудыг давхардуулан олгож байна. Иймд мөнгөн урамшууллыг давхардуулан олгож байгаа асуудлыг эрүүл мэндийн системийн хэмжээнд энэ зөрчилтэй асуудлыг давтан гаргахгүй байхыг Эрүүл мэндийн яаманд уламжлах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

### 42. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:

Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг анх 9239.1 сая төгрөгөөр баталж, жилийн явцад 712.8 сая төгрөгөөр бууруулж зохицуулалт хийж 8526.3 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 8142.4 сая төгрөг зарцуулж, зардлыг 383.9 сая төгрөгөөр хэмнэсэн нь дараах шалтгаантай байна.

*Хүснэгт 19..Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал /сая төгрөг/*

| д/д | Зардлын ангилал | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Гэрэл цахилгаан | 543.4 | 483.0 | 60.5 |
| 2 | Түлш халаалт | 7464.4 | 7162.6 | 301.8 |
| 3 | Цэвэр бохир ус | 439.9 | 418.2 | 21.6 |
| 4 | Байрны түрээс | 78.6 | 78.6 | 0.0 |
| | Нийт дүн | 8526.3 | 8142.4 | 383.9 |

*Эх үүсвэр:Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Монгол Улсын засгийн газраас Ковид-19 вируст халдвараас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020.01.27-ний өдрөөс эхлэн бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг түр зогсоосноос шалтгаалж БСШУС-ын сайдын 2020.04.13-ний өдрийн 1а/2235 дугаар албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.04.22-ний өдрийн А/287 дугаар захирамжаар сургууль, цэцэрлэгийн халаалтын зардлыг 2020.05.01-ний өдрөөс эхлэн зогсоосон ба аймгийн төвийн 5 дугаар арван жил ашиглалтад ороогүйтэй холбогдуулан түлш халаалтын зардлаас 108.8 сая, цэвэр бохир усны зардлаас 5.8 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Баянхонгор сумын 2-р цэцэрлэг 1.5 сая, Галуут сумын ЕБС 0.9 сая, Галуут сумын ЕБС 1.0 сая төгрөгийн халаалтын зардлыг гэрээнээс илүү төлсөн;*
- *Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль түлш халаалтын зардлаас 6.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.*

### 43. Үдийн цайны зардал:

Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдад олгох үдийн цайны зардлыг өмнөх оноос 640.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1424.0 сая төгрөгөөр баталсан нь Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн 450 дугаар тогтоолоор нормативт зардлыг 2020.01.01-ний өдрөөс 900 төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Үдийн цайны зардлаас ЕБС-ийн хэмнэлтийн дансанд 478.3 сая, аймгийн Засаг даргын захирамжаар 2 удаа зохицуулалт хийж 176.1 сая төгрөгийн төсөв

батлагдсанаас 451.1 сая төгрөг зарцуулж 321.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Баян-өйт цогцолбор сургууль нэг хүүхдэд зарцуулах нормативыг 375 төгрөгөөр хэтрүүлж 1.5 сая төгрөгийг илүү олгосон байна.*

44. **Хоолны зардал:**

Аймгийн дүнгээр хоолны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 1885.8 сая төгрөгөөр өсгөж, 4355.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3189.9 сая төгрөг зарцуулж, 1165.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Ерөнхий боловсролын дотуур байрны хүүхдийн хоолны зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн 450 дугаар тогтоолоор 2020.01.01-ний өдрөөс дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3475 төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 3600 төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.

*Хүснэгт 20. Хоолны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

| д/д | Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Сургууль | 796.6 | 480.0 | 316.6 |
| 2 | Цэцэрлэг | 794.2 | 785.5 | 8.7 |
| 3 | Эрүүл мэндийн төв | 100.8 | 99.2 | 1.7 |
| 4 | ЕБС-ын ТЗШ-ийн хэмнэлт | 1216.5 | 828.2 | 388.3 |
| 5 | СӨБ-ийн ТЗШ-ийн хэмнэлт | 1404.3 | 956.1 | 448.3 |
| 6 | Бусад төсөвт байгууллагууд | 42.6 | 41.0 | 1.5 |
| | Дүн | 4355.1 | 3189.9 | 1165.2 |

*Эх сурвалж. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас ЕБС-ийн ТЗШ-ийн хэмнэлтийн дансанд 1010.4 сая төгрөг төвлөрүүлж, аймгийн засаг даргын захирамжаар 2 удаа зохицуулалт хийж 796.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 480.0 сая төгрөгийг зарцуулж 316.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлаас СӨБ-ийн ТЗШ-ийн хэмнэлтийн дансанд 1404.3 сая төгрөгийг төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар 796.3 сая төгрөгийг төсөвт зохицуулалт хийж 794.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 785.5 сая төгрөгийг зарцуулж 8.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын явцад хийсэн судалгаагаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлаас 205.3 сая төгрөгийг зарцуулснаас ковид цар тахалтай холбогдуулан эргүүл, постод гарсан албан хаагчдын хоолны зардалд 193.1 сая, тусгаарлах байрны хоолны зардалд 10.8 сая мөн аж ахуйн нэгжээр бэлтгүүлсэн хоолны зардалд 1.4 сая төгрөг олгосон байна.

Эргүүл постод ажилласан албан хаагчдын хоолны зардлын гүйцэтгэлийг Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалаар баталсан төрийн албан хаагчийн албан томилолтын нэг өдрийн зардалтай харьцуулахад аймгийн төвийн 11, сумын 3

төсөвт байгууллага албан томилолтын нэг өдрийн зардлаас 346-12499 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Зарим сумд төсвийн зардлыг хэмнэх үүднээс сумын хэмжээнд өдөрт 2500 төгрөгийн хоол олгох шийдвэрийг гаргасан байхад аймгийн төвийн хэмжээнд жишиг нормыг тогтоож өгөөгүйгээс төсөвт байгууллагууд харилцан адилгүй зардал гаргасан байна. Иймд цаашид зардлын нормыг нэгдсэн журмаар тогтоож, зардлын хяналтыг сайжруулах шаардлагатай тул аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

45. **Томилолт, зочны зардлын** 2019 оны гүйцэтгэл 574.9 сая төгрөг байсан ба тайланд онд тус зардлын бүлгийг 261.1 сая төгрөгөөр бууруулж, 388.7 сая төгрөгөөр баталснаас 313.8 сая төгрөгийг зарцуулж, 74.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 21. Томилолт зочны зардлын харьцуулсан судалгаа / сая төгрөгөөр/*

| Зардлын төрөл | 2019 он | | | 2020 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт |
| Гадаад албан томилолт | 78.9 | 77.7 | 1.2 | 19.3 | 18.3 | 1.0 |
| Дотоод албан томилолт | 388.8 | 359.7 | 29.1 | 322.7 | 249.5 | 73.2 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах зардал | 123.5 | 137.5 | -14.0 | 46.8 | 46.0 | 0.8 |
| Дүн | 591.1 | 574.9 | 16.2 | 388.7 | 313.8 | 74.9 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

ТШЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зочин төлөөлөгчдийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг тогтоож, төлбөрийн акт тогтоож, менежментийн захидлаар зөвлөмж өгсний үр дүнд 2020 онд зочин төлөөлөгч авах зардлыг өмнөх оноос 76.7 сая төгрөгөөр бууруулан төлөвлөж, зардлыг зориулалтыг дагуу зарцуулж, аудитаар зөрчил илрээгүй нь аудитын үр өгөөж гарсныг харуулж байна.

Гадаад албан томилолтын зардлыг тайлант онд 19.3 сая төгрөгөөр төлөвлөж, аймгийн ИТХ сумдын ИТХ-ын дарга нарыг Турк улс руу ажиллуулж, 18.3 сая төгрөгийг зарцуулсан бол Баянцагаан сумын ЗДТГ тус зардалд батлагдсан 1.0 сая төгрөгийг зарцуулаагүйг байна.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар 2 албан хаагчдад албан томилолтын хуудасгүй 0.9 сая төгрөгийн албан томилолт олгосон байна.*

**Тээвэр, шатахууны зардал:**

Тайлант онд тээвэр, шатахууны зардлыг 1174.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1131.9 сая төгрөг зарцуулж, зардлыг 42.4 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2015.05.11-

ний өдрийн батлагдсан "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 184 дүгээр тогтоолын 8-т заасан "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" гэснийг заалтуудыг зөрчиж төсвөөс санхүүждэг байгууллагууд цилиндрийн багтаамж өндөртэй, шатахууны зарцуулалт их суудлын автомашин худалдан авах хандлага сүүлийн жилүүдэд ихсэж байгаад цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Баянцагаан сумын ИТХ-ын 2020.09.29-ны өдрийн 17/4 тоот хурлын хуралдааны тогтоолоор сумын ЗДТГ –ын урсгал засварт 4.0 сая төгрөг батлагдсаныг 12.3 сая төгрөг болгон тодотгон, Баянцагаан сумын ЗДТГ-т бүртгэлтэй 73-24 БНА улсын дугаартай TLC 200 автомашинд 7.3 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийлгэж, 0.8 сая төгрөгийн зогсоолын төлбөр төлсөн байна. Дээрх автомашин нь 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 59.8 сая төгрөгөөр худалдан авсан хуучин ашиглаж байсан автомашины бөгөөд ашигласнаас хойш 3 жилийн дотор их засварт орж байгаа нь төсөвт их хэмжээний зардал үүсгэж байна.*
- *Баянбулаг сумын ЗДТГ нь сумын Засаг даргын 2020.12.17-ны өдрийн Б/120 тоот захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын цагдаагийн хэсэгт 7.0 сая төгрөгөөр автомашин авах шийдвэр гарсны дагуу 2020.12.16-ны өдөр иргэн Б.Төрбаттай гэрээ байгуулан 6.2 сая төгрөгөөр "probox" маркийн автомашин худалдан авч төсвийн зориулалт бусаар зарцуулсан.*
- *ТӨБЗГ-ын 2020.04.21-ны өдрийн 169 тоот тогтоол, Барилга, хот байгуулалтын яамны 2020.05.06-ны өдрийн 03/1690 тоот албан бичгээр захиалагчийн техник хяналтын зардлаас Баянхонгор аймгийн ГХБХБГ-т 127.7 сая төгрөгийн дээд хязгаарт багтаан суудлын автомашин худалдан авах шийдвэрийг зөрчиж аймгийн Засаг даргын 2020 оны А/694 тоот захирамжаар 20.0 сая төгрөгийг нэмж нийт 147.7 сая төгрөгөөр суудлын автомашин худалдан авч төсвийг хэтрүүлэн зарцуулсан.*
- *Баацагаан сумын ЕБС 0.4 сая, Шинэжинст сумын эрүүл мэндийн төв 2.4 сая төгрөгийн шатахууны орлогыг шууд зардлаар бүртгэсэн;*
- *Баян-Овоо сумын ЗДТГ 20.4 сая, 13-р цэцэрлэг 1.0 сая, Өлзийт сумын ЗДТГ 0.6 сая төгрөгийн шатахууныг замын хуудасгүй зарцуулсан;*
- *Баянхонгор аймаг ИТХ шатахуун картын хөнгөлөлтийн орлогоор 0.5 сая төгрөгийн хөнгөлөлт авсан байхад үнэ төлбөргүй орлогоор бүртгээгүй;*
- *Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Нягтлан бодогч тээвэр шатахууны зардлыг тооцоог бодохдоо спидометрийн заалтын үндэслэн тооцоог бодоогүй, албаны дарга Улаанбаатар руу эрх бүхий албан тушаалтны томилсон томилолт болон явсан ажлын талаар тайлан байхгүй 1-5 сард 4 удаа 1.8 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан;*
- *Жинст сумын сургууль тээвэр шатахууны зардалд 4.1 сая төгрөг батлагдсан бөгөөд 9.4 сая төгрөгийн шатахууны зардал зарцуулсан ба хоолны зардлаас 5.2 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан.*
- *Жинст сумын сургууль Их богдын ундарга ХХК-д 2020.03.03-ны өдөр сургуулийн захирлын гарын үсэггүй 1.8 сая төгрөгийн төлбөрийн баримтаар сумын төрийн сангийн төлөөлөгч шатахууны гүйлгээг хийсэн;*
- *Жинст сумын ЗДТГ оны эцэст шатахууны зардалд нэмж тодотгол хийж, НИК ХХК-д 4.0 сая төгрөгийг шилжүүлж, шатахууны үлдэгдэлтэй гарч бараа материал нөөцөлсөн.*
- *Шинэжинст сумын ЗДТГ цагийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор отрын малчныг эргэх, төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор шатахууны бэлтгэн нийлүүлэгчид 3.0 сая төгрөгийн шатахуун шилжүүлж, шатахуун хүлээн аваагүй байхад бараа материалын орлогоор бүртгэсэн.*

46. **Хөрөнгийн зардал:**

Тус зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 2765.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 9349.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 6891.7 сая төгрөгийн зардал олгож, 1837.5 сая төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн дансанд оны эхэнд 1103.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайланд онд зээл, зээлийн хүүгийн орлогоор 1499.0 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдаж гүйцэтгэлээр 1346.6 сая төгрөгийн сая төгрөгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлж, 138 зээлдэгчид 954.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, сангийн үйл ажиллагааны зардалд 17.3 сая төгрөгийг зарцуулан оны эцэст 1477.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Баянхонгор, Бууцагаан, Өлзийт, Жинст ,Баянлиг, Баянговь сумууд СХС-ийн эхний үлдэгдэлтэй, тайлант онд зээлийн эргэн төлөлтийн орлого орсон байхад хөнгөлөлттэй зээлийг сумын иргэдэд олгож, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллаагүй;*
- *Бүх сумд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчийн тоо, насжилт өндөртэй авлага их байхад зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

**Орон нутгийн хөгжлийн сан:**

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд 9367.7 сая төгрөгийн 320 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 220 ажлыг бүрэн, 50 ажлыг дутуу хэрэгжүүлж, 7530.3 сая төгрөгийг зарцуулсан бол 942.7 сая төгрөгийн 50 ажил огт хэрэгжээгүй байна.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Баянлиг сумын Засаг дарга, “Хар ботго” хоршоотой 2020.02.05-ны өдөр “Баянлиг сумын гэр хороололд гэрэлтүүлэг хийх” 03 тоот гэрээ байгуулан, 2020 оны 2 сарын 08-ны өдөр тус хоршооны 230400002357 тоот харилцах дансанд гэрэлтүүлгийн ажлын үнэ 10.0 сая төгрөг шилжүүлсэн боловч 2020.12.31-ны өдрийн байдлаар тус гэрэлтүүлгийн ажил хийгдээгүй байна.*
- *Баянцагаан сумын орон нутгийн хөгжлийн сан нь мал эмнэлгийн барилгын 60.0 сая төгрөгийн өртгөөс 20.0 сая төгрөгийг "Баялаг Өлзий" ХХК-тай 2020.12.18-ны өдөр барилгын ажил гүйцэтгэх шууд гэрээ байгуулан олгосон ба тус барилга нь мэргэжлийн байгууллагын зураг төсөв хийгдээгүй, ажил эхлээгүй байна;*
- *Богд сумын орон нутгийн хөгжлийн сан 4.4 сая төгрөгөөр өвс тэжээл худалдан санхүүгийн тайланд бүртгээгүй;*
- *Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гэрээг гүйцэтгэх боломжгүй цаг хугацаанд байгуулж, ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй байхад Бууцагаан сумын ОНХС-аас гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд оны эцэст 58.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон атлаа авлагаар тусгаагүй байна.*

***Замын сан:***

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ны өдрийн 18/16 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 500.0 сая, орон нутгийн авто зам ашигласны төлбөр 220.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний өдрийн №18/16 тогтоолоор өмнөх оны үлдэгдэл 20.7 сая төгрөгийг нэмж тодотгон нийт 740.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Аймгийн автозамын сангийн хөрөнгөөр 2020 онд өмнөх оноос шилжих 2 төсөл, арга хэмжээнд 351,3 сая, 2020 онд шинээр хэрэгжүүлэх 10 төсөл, арга хэмжээнд 378,1 сая, автозамын тухай хуулийн 24.5-д заасан хяналтын зардалд 11,3 сая төгрөг олгохоор тус тус төлөвлөжээ.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 20.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба АТБӨЯХАТ-аар 587.5 сая, авто зам ашигласны хураамжийн орлогоор 253.2 сая, 840.7 сая төгрөг оруулснаас орон нутгийн орлогоос олгохоор батлагдсан 720.0 сая төгрөгийг олгож, 11 батлагдсан төсөл, арга хэмжээнд 728.5 сая төгрөгийн зардал гаргаж 12.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## Ангилагдаагүй зардал:

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолоор ангилагдаагүй зардалд 33 хөтөлбөр, арга хэмжээнд 3621.5 сая төгрөг баталсан ба тайлант онд 5 удаагийн захирамжаар 19 төсөл арга хэмжээний 1008.4 сая төгрөгийг хасаж , 6 төсөл арга хэмжээний 694.9 сая төгрөгийг нэмж батлан, нийт 3308.0 сяа төгрөгийг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 3199.9 сая төгрөг зарцуулж 108.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 22 . Ангилагдаагүй зардалд хийсэн зохицуулалтууд /сая төгрөгөөр/*

| № | Захирамжийн огноо, дугаар | Нэмсэн арга хэмжээний | | Хассан арга хэмжээний | |
|---|---|---|---|---|---|
| | | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | Аймгийн Засаг даргын 2020.05.19-ний өдрийн А/347 дугаар захирамж | | | 2 | 95.0 |
| 2 | Аймгийн Засаг даргын 2020.07.09-ны өдрийн А/446 дугаар захирамж | | | 2 | 124.0 |
| 3 | Аймгийн ИТХ-ын 2020.09.18-ны өдрийн 21/03 хурлын тогтоол | 6 | 694.9 | 6 | 163.8 |
| 4 | Аймгийн Засаг даргын 2020.10.27-ний өдрийн А/701 дугаар захирамж | | | 1 | 347.6 |
| 5 | Аймгийн Засаг даргын 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамж | | | 8 | 278.0 |
| | Дүн | 6 | 694.9 | 19 | 1008.4 |

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 713.6 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 713.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

***Аудитын илрүүлэлт:***

- *Ангилагдаагүй зардлаас оны эхэнд гадаад арга хэмжээний зардалд 30.0 сая төгрөг батлагдаж, аймгийн ИТХ-ын 2020.09.18-ны өдрийн 21/03 дугаар тогтоолоор 1.5 сая төгрөг хасаж 5 улсад 11 төрийн албан хаагч 28.4 сая төгрөгийг зарцуулсан ажилласан байна. Зардлын зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 14.4 сая төгрөг нь 2019 онд ажилласан гадаад албан томилолтын зардал байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4[11] дэх, 14 дүгээр зүйлийн 14.4.3[12] дахь заалтыг зөрчиж байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.*

[11] *Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.*

[12] *Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: Бүх өр төлбөр;*

### 47. Техник хяналтын барьцаа данс

Барьцаа хөрөнгө оруулалт дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1601.8 сая төгрөг, тайлант хугацаанд цэвэр дүнгээр 1760.3 сая төгрөгийн орлого төвлөрч, 1285.7 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцсийн үлдэгдэл 2076.4 сая төгрөг байна.

Төрийн сан дахь 100030051370 тоот Бх.Техник хяналт зардлын дансанд оны эхэнд 503.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд 419.4 сая төгрөг төвлөрч, 494.3 сая зарцуулалт гарч оны эцэст 428.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

***Аудитын илрүүлэлт:***

- *Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.07.08-ны өдрийн 111/ШШ2019/00201 дугаар захирамжаар 13.5 сая төгрөг олгуулахаар шийдвэрлэснээс техникийн хяналтын зардлаас 2020.01.20-ны өдөр 13.5 сая төгрөгийг олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1[13] дэх заалтыг зөрчсөн тул Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2[14] дахь заалтын дагуу Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд албан шаардлагыг бичиж хүргүүлэв.*

### 48. Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.




Тайлант онд давхардсан тоогоор 171 байгууллагад 6917.7 сая төгрөгийн орлого байна.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 81 байгууллага 4277.3 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 2 байгууллага 596.3 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө тэтгэмжид 23 байгууллага 598.9 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 60 байгууллага 919.1 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд нэг байгууллага 5.0 сая, хөрөнгийн зардалд 2 байгууллага 6.0 сая нийт 6402.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 515.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

---

*[13] Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ*

*[14] Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна*

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 596.3 сая төгрөг олгосон нь аймгийн ИТХ-ын нэмэлт дансаар 562.0 сая төгрөгийг хэлмэгдэгсдийн ар гэрт олгосон цагаатгалын нөхөн төлбөрт, Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн албан хаагчийн ар гэрт 34.3 сая төгрөгийн тэтгэмж олгосонтой холбоотой байна.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад нийт 919.1 сая төгрөг олгосныг байгууллагын төрлөөр нь авч үзвэл эрүүл мэндийн салбарын албан хаагчдад 178.2 сая, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчдад 577.4 сая, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдад 163.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос давсан орлого, мөн төлөвлөөгүй орлогыг төсөвт байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансандаа төвлөрүүлж зарцуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байхад СТСХ гүйлгээ хийсэн нь Сангийн сайдын 2019.03.27 ний өдрийн 74 тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт, орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг зөрчсөн зөрчил зарим байгууллагад илрэв. Аймгийн Засаг дарга 2020.12.03-ны өдөр нэмэлт орлогыг зарцуулах тухай А/785 дугаар захирамжийг гаргахдаа байгууллага бүрээр хавсралтаар баталж өгөөгүйгээс дээрх алдаа жил бүр давтагдан гарах үндэс болж байгаа тул нэмэлт орлогыг зарцуулах шийдвэрийг хавсралтын дагуу гаргах албан шаардлагыг Аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Мөн Төсөвт байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас төвлөрсөн мөнгийг зарцуулахдаа анхан шатны баримтыг бүрдэл дутуу, зарим гүйлгээг дансаараа дамжуулан олгосон зөрчил илэрлээ.

***ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:***

- *Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нэмэлт санхүүжилтийн дансанд 23.5 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг Засаг даргын захирамж гараагүй байхад 9.4 сая төгрөгийг зарцуулсан байна.*

## БҮЛЭГ 3. АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАЖ АЖИЛЛАСАН Ч ЗӨРЧЛҮҮД БҮРЭН АРИЛААГҮЙ БАЙНА.

49. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2[15] дахь заалтын дагуу өмнөх аудитын зөвлөмжийн хариуг 2020.09.30-ний өдрийн 1а/562 дугаар албан бичгээр гаргаж ирүүлсэн байна.

50. Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг гарган ажилласнаар мэргэжилтнүүдийн ажлын хариуцлага, арга барил өмнөх оноос сайжирсан давуу талтай хэдий ч аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2020 оны аудитаар гарсан алдаа зөрчилтэй харьцуулан үнэлэхэд зөвлөмжийн биелэлт 70.5%-тай үнэлэгдэж байна.

---

*[15] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.*

*Хүснэгт 23 . Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт*

| № | Өгсөн зөвлөмж | | Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт |
|---|---|---|---|
| **Нэг. Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа нарт** | | | |
| 1 | Аймаг, сумдын ИТХ-аар баталсан тогтоолыг хянан хүлээн авч, Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд эх үүсвэр, зардлыг үнэн зөв оруулах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Сумдын ИТХ-аар баталсан тогтоол, сумдын засаг даргаар батлуулсан төсөвт байгууллагын сарын хуваарийг 01 дүгээр сарын 15-ны дотор тулган баталгаажуулан, төсвийн төлөвлөлтийн программд оруулсан. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Сумдын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг хянаагүйгээс 3 сумын урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 10.8 сая төгрөгөөр зөрүүтэй баталсан, Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 2.0 сая төгрөгөөр баталсан байхад өөрийн орлогын төлөвлөгөөг 1.0 сая төгрөгөөр зөрүүтэй оруулсан. **Биелэлт 90%** |
| 2 | Төсөвт байгууллагуудын төсвийн төсөлд тавих хяналтыг сайжруулж, төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийдэг, зохицуулалт хийсэн шийдвэрийг гүйлгээ гарсны дараа гаргадаг байдлыг таслан зогсоох. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Төсвийн зохицуулалтыг сар бүр хийдэг байсныг зогсоож, Засаг даргын захирамжийг үндэслэн жилд 1-2 удаа хийхээр төлөвлөн ажиллаж байна. Эхний улирлуудын байдлаар зохицуулалт хийгээгүй. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Тухайн онд төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар 6 удаа зохицуулалт, 1 удаа аймгийн ИТХ-ын тогтоолоор тодотгол хийсэн байна. Хамгийн сүүлийн удаа аймгийн Засаг даргын 2020.12.30-ний өдрийн А/850 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байгаа нь зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. **Биелэлт 50%** |
| 3 | Оны эцэст хэмнэгдсэн мөнгийг зориулалт бусаар зарцуулж, санхүүгийн тайланд авлагаар тусгадаг байдлыг давтан гаргахгүй байх. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Тайлант онд төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал бүр гаргуулж, буруу тусгагдсан авлагуудыг залруулж ажиллаж байна. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Тухайн онд төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар 6 удаа зохицуулалт, 1 удаа аймгийн ИТХ-ын тогтоолоор тодотгол хийсэн байна. Хамгийн сүүлийн удаа аймгийн Засаг даргын 2020.12.30-ний өдрийн А/850 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байгаа нь зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. **Биелэлт 10%** |
| 4 | Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллын дагуу санхүүгийн тайланд зардлыг зөв тайлагнах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Free balance программын хэлбэлзлийн тайлантай тулган баталгаажуулан, төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, төсвийн төлөвлөлтийн дагуу санхүүгийн тайланд зөв тусгуулж ажилласан. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллын дагуу гүйлгээг хянахгүй байна. **Биелэлт 85%** |
| 5 | Сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж байгаа Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Сум хөгжүүлэх сангийн зээлийг гэрээ, төсвийн дагуу зарцуулах, түүний бүртгэлийг үнэн зөв хөтлөх, программ ашиглалтыг сайжруулах үүднээс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын сум хөгжүүлэх сан, хоршоо хариуцсан мэргэжилтнээр сумдын нягтлан бодогч нарт сургалт явуулсан. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Тайлант онд сум хөгжүүлэх сангийн зээлийн орлогоор 1499.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 1346.6 сая төгрөгийн орлого оруулж 89.8 хувийн биелэлттэй байна. **Биелэлт 89%** |
| 6 | Соёлын байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхаарч, орлогыг харилцах дансанд төвлөрүүлэлгүй зарцуулж байгаад хяналт тавьж ажиллах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Төсөвт байгууллагын өөрийн орлогыг байгууллага, хамт олноор хэлэлцэн баталж, нэмэлт санхүүжилтийн дансанд оруулж, батлагдсан зардлын дагуу эрхийг нээж, төлбөр тооцоог гүйцэтгэн ажиллаж байна. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Тайлант онд 6 соёлын төвд 9.3 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 5.2 сая төгрөгийн орлого оруулж 56 хувийн биелэлттэй байна. **Биелэлт 56%** |
| 7 | Төсөвт байгууллагуудад өндөр настны тэтгэвэрт гарсан хүмүүсийн ажлыг Төрийн албаны зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу зохион байгуулж, нийгмийн даатгалын шимтгэлийг зөв | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Өндөр насны тэтгэвэрт гарч буй төрийн албан хаагчдад тэтгэвэрт гарсны тэтгэмж олгохдоо ажлаас чөлөөлөгдсөн тушаал, тэтгэврийн дэвтрийг үндэслэн олгодог болсноор тухайн асуудалтай зөрчилтэй багассан. тэтгэвэрт гарсан албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг зөв мэдээлүүлж, байгууллагын албан хаагчдын цалингаас хоолны мөнгө, утасны төлбөр болон бусад суутгалыг хийдэг байдлыг зогсоосон. |

| | | | |
|---|---|---|---|
| | мэдээлж, байгууллагын ажиллагсдын цалингаас Хөдөлмөрийн тухай хуульд заагдаагүй хоолны мөнгө, утасны төлбөр зэрэг бусад суутгалыг хийдэг байдлыг зогсоох. | Аудитаар тооцсон биелэлт | Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар өндөр настны тэтгэвэрт гарсан 22 кодоор мэдээлдэг албан хаагчдыг кодыг буруу мэдээлснээс зарим төсөвт байгууллагууд залруулга хийгдсэн, зарим байгууллагад тэтгэвэрт гарсан албан хаагчид байсаар байна. **Биелэлт 85%** |
| 8 | Техник хяналтын барьцаа данснаас холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтад тулгуурлан зардлыг олгож, бусад байгууллагатай үүссэн авлагын тооцоог бүрэн барагдуулж ажиллах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Барьцаа дансанд авсан мөнгийг буцааж олгохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу баримтыг бүрдүүлж 1142.7 сая төгрөгийн авлагыг буцаан олголоо. Техник хяналтын барьцаа данснаас холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтад тулгуурлан зардлыг олгож байна. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | 2019 оны эцэст 16 төсөл арга хэмжээний зураг төсвийн авлагаар 238.5 сая төгрөгийн авлагатай байсан бөгөөд 2020 онд авлагын 16.7 хувь буюу 40.0 сая төгрөгийг барагдуулсан ба зарим авлагын барагдах хугацаа болоогүй байна. **Биелэлт 70%** |
| 9 | Төсөвт байгууллагын нягтлан бодогч нар Э-тайланд ажиллагсад, хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсдын тоог үнэн зөв оруулж байгаад санхүүгийн албадын дарга нар хяналт тавьж ажиллах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Төсвийн Гүйцэтгэлийн хагас жилийн тайланд төсөвт байгууллагуудын хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсдын тоог үнэн зөв тайлагнасан. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Төсөвт байгууллагууд санхүүгийн тайлангийн статистик үзүүлэлтүүдийг бүрэн оруулж, зөрүүтэй мэдээлэл засч оруулан хяналт тавьж ажиллаж байгаа гэсэн хариуг ирүүлсэн боловч ТТЗ-ын санхүүгийн тайлангаар статистик үзүүлэлтүүдэд залруулга хийгдсэн. **Биелэлт 80%** |
| **Хоёр.Аймгийн Татварын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Рэнцэндагва танаа** | | | |
| 10 | Сумын ИТХ-аар баталсан татварын орлогын төлөвлөгөөг татварын мэдээнд үнэн зөв мэдээлж, орлогын эдийн засагчийн ажлын хариуцлагыг сайжруулж, аймгийн нэгдсэн тайланд татварын орлогын гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлж байгаад хяналт тавьж ажиллах. | Байгууллагаас ирүүлсэн тайлбар | Зөвлөмжийн дагуу ажиллаагүйгээс аймгийн СТСХ, Татварын хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын уялдаа хангалтгүй байна. |
| | | Аудитаар тооцсон биелэлт | Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. **Биелэлт 90%** |
| | | | **БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 70.5%** |

*Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн 2020.09.30-ний өдрийн 1а/562 дугаар албан бичиг*

Өмнөх онуудтай харьцуулахад аймгийн ЗДТГ-ын СТСХ нь аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг хянаж хүлээн авсан, тогтоолыг нэгтгэж Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн, орон нутгийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ тайлан, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг дэлгэрэнгүй ирүүлсэн сайн талтай ч өмнөх онд өгсөн дараахь зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, алдаа зөрчил давтагдсан байна.

***Аудитаар илэрсэн зөрчил:***

- *“Төсөвт байгууллагуудын төсвийн төсөлд тавих хяналтыг сайжруулж, төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийдэг, зохицуулалт хийсэн шийдвэрийг гүйлгээ гарсны дараа гаргадаг байдлыг таслан зогсоох”, “Оны эцэст хэмнэгдсэн мөнгийг зориулалт бусаар зарцуулж, санхүүгийн тайланд авлагаар тусгадаг байдлыг давтан гаргахгүй байх” зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 дүгээр албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын 26 сургууль тус бүрд "Хичээл практик"-ийн зардлыг 10.0 сая, нийт 260.0 сая төгрөгөөр нэмж тодотгон, гүйцэтгэлээр сургууль бүр 9.9 сая төгрөг, аймгийн дүнгээр нийт 258.1 сая төгрөгийн ухаалаг самбарын үнийг 12 дугаар сарын сүүлээр шилжүүлж, хөрөнгөд орлого аваагүй авлага үүсгэж, өмнөх оны алдааг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн*

*21.1[16], Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10[17] заалтыг үндэслэн оны эцэст хэмнэгдсэн мөнгийг тодотгож, хөрөнгө бэлтгэдэг явдлыг таслан зогсоох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв. Аудитаар дээрх бэлтгэсэн ухаалаг самбарын судалгааг аймгийн дүнгээр нэгтгэхэд "Санко Маркетинг Монолиа" ХХК-аас 17 сургуульд 169.2 сая, "Дэвших болор" ХХК-аас 9 сургуульд 88.9 сая төгрөгийн самбар авсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6[18] дахь заалттай нийцэхгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулж, хэмнэлт үүсэж төсвийг хэмнэх боломжийг алдсан байна.*

- *"Төсөвт байгууллагын нягтлан бодогч нар Э-тайланд ажиллагсад, хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсдын тоог үнэн зөв оруулж байгаад санхүүгийн албадын дарга нар хяналт тавьж ажиллах" зөвлөмжийг сумдын санхүүгийн албаны дарга нар хэрэгжүүлээгүйээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн орлого, зардлын ангиллыг Сангийн яамны Э-тайланд зөрүүтэй оруулсан алдаа зөрчил илэрсэн.*

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2020 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5[19]-т заасан бүрэлдэхүүнээс 54.5.1, 54.5.4 дэх заалтад заасан тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хөтөлбөр, төсөв захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр гаргаж ирүүлээгүй, аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг хангалтгүй гаргаж ирүүлсэн, ихэнх сумдын ИТХ байгууллага, сангуудын тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг батлаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6[20] дахь заалттай нийцэхгүй тул аймгийн ЗДТГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн даргад зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар нийт 293.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 283.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгч, 9.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмжийг хүргүүлэв.

---

[16] *Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*

[17] *Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгнө.*

[18] *Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хуваах тендер шалгаруулалт явуулж болно.*

[19] *Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:*

[20] *төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;*

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Нэг. Төрийн сангийн гүйлгээ хаасны дараа Баянхонгор аймгийн Засаг дарга 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжийн талаар аймгийн СТСХ-ийн төсвийн 2 мэргэжилтнээс тодруулахад “Төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, тэвчиж болох зардлуудын хуваарийг хойшлуулахдаа төсвийн үлдэгдэл, зарцуулах эрхийг зөрүүлж татсан, хойшлуулсан зардлын эрхийг нээхдээ зарцуулах эрхийг давхардуулан татсантай холбоотой 2020 оны батлагдсан төсвөөс илүү зарцуулалт гаргасныг 2021.01.12, 2021.01.28-ний өдрүүдэд залруулга хийх файл ирсний дагуу 2 удаагийн залруулга хийсэн, Сангийн яам нь аймгийн ТЕЗ-ийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулдаг, орон нутгаас санал авахгүйгээр шийдвэрлэдэг” гэсэн тайлбар бичгийг ирүүлсэн байна.

Энэ байдал нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.2 заалтуудыг зөрчиж байгаа тул “Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан төсвийг хянаж хүлээн авч, төсвийн төлөвлөлтийг үнэн зөв оруулж, төсвийн орлого, зардлыг үнэн зөв тайлагнаж байгаад тавих хяналтыг сайжруулж, программын хөгжүүлэлтийн нэн даруй хийх” саналыг Сангийн яаманд уламжлах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлж байна.

Хоёр. Эрүүл мэндийн сайдын 2020.08.10-ны өдрийн А/392 дугаар тушаал, 2020.08.10-ны өдрийн 1а/3345 дугаар албан бичигт эрүүл мэндийн сайдын багцын байгууллагуудын 2020 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж ажлын үр дүнгээр хангалттай үнэлгээ авсан байгууллагуудын дарга, ахлах нягтлан бодогч, эдийн засагч, нярав нарт батлагдсан төсөвт багтаан урамшуулал олгох шийдвэрийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, ахлах нягтлан бодогч, төсвийн мэргэжилтэн, нярав нарт 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгосон байна.

Мөн дээрх тушаалыг үндэслэн Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга тушаал гаргаж, аймгийн Зооноз өвчин судлалын төвийн дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга, ерөнхий нягтлан бодогч нарт урамшуулал олгосны зэрэгцээ цар тахалтай холбоотой 2020 оны 1, 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал болон 2020 оны хагас жилийн ажил дүгнэсэн урамшуулал олгож төсвөөс урамшууллуудыг давхардуулан олгож байна. Иймд мөнгөн урамшууллыг давхардуулан олгож байгаа асуудлыг эрүүл мэндийн системийн хэмжээнд энэ зөрчилтэй асуудлыг давтан гаргахгүй байхыг Эрүүл мэндийн яаманд уламжлах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангийн орлогоос бусад орлогыг бүрэн оруулж, орон нутгийн орлогын төлөвлөгөөг 112.7% буюу 1680.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан байна.
2. Ихэнх сумдын ИТХ сумын төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллага, сангуудын тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тогтоолын хавсралтаар баталж, Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн Piscal программд төсөвт байгууллагуудын зарцуулах эрхийг зөрүүтэй татаж, төсвийн төлөвлөлтийг гарсан зардлаар тайлагнаснаас төсвийн төлөвлөлтийн үндэслэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.
4. Аймгийн Эрүүл мэндийн төсвийн мэргэжилтэн сумдын Эрүүл мэндийн төвийн төсвийн төслийг байгууллага бүрээс гаргуулан авдаггүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалттай нийцэхгүй байна.
5. Сумдын ИТХ төсөв баталсан тогтоолд урьд оны үлдэгдлийг 10.8 сая төгрөгөөр зөрүүтэй баталж, Эрдэнэцогт сумын ИТХ-аар баталсан ЗДТГ-ын өөрийн орлогыг төсвийн төлөвлөлтийн программд 1.0 сая төгрөгөөр зөрүүтэй оруулсан байна.
6. Аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн асруулагчийн тэтгэврийн 30 хувийг тухайн байгууллагын төсвийн бүрэлдэхүүнд оруулж батлаагүй байна.
7. Төсвийн зарцуулалтад тавих төрийн сангийн дотоод хяналт сул, ажилтнуудын ур чадвар дутмаг байгаагаас төсвийг зориулалт бусаар зарцуулдаг, нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу хөтөлж санхүүгийн тайланг бэлтгээгүйгээс төсвийн шууд захирагчийн тайланд хийсэн аудитаар нийт 4638.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.
8. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ажиллаж байгаа ажилтнуудын хоолны зардлыг олгох нэгдсэн журмаар нэг өдөрт ногдох зардлын нормативыг тогтоогүйгээс байгууллагууд харилцан адилгүй зардал гаргажээ.
9. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан ч зөрчлүүд бүрэн арилаагүй, давтагдан гарсаар байна.
10. Аймгийн ЗДТГ-ын СТСХ төсөвт байгууллага, сангийн батлагдсан анхны болон тодотгосон төсвийн хуваарийг эх үүсвэр, зардлын ангиллаар гаргаж, нэгтгэж гаргаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

6417143544
ВЮА0067 9007423

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:**

**Нэг. Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танаа**

1. Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллах.
2. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд гарч байгаа ажилтнуудад хоолны зардлыг олгох талаар нэгдсэн шийдвэр гаргаж, Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
3. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх "Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх" заалтыг хэрэгжүүлж, сумдын Эрүүл мэндийн төвөөс төсвийн төслийг хүлээн авах.
4. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 2.1.10-т заасны дагуу асруулагчийн тэтгэврийн 30 хувийг аймгийн Асрамжийн газрын төсвийн бүрэлдэхүүнд оруулж батлах.
5. Байгууллага, сангийн анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайланд тавих сумдын санхүүгийн албаны дарга нарын үүрэг оролцоог нэмэгдүүлж, сангийн яамны Э-тайланд 2021 оны эхний хагас жилийн тайланд өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар зөв оруулсан эсэхэд аймгийн СТСХ-ээс хяналт тавих.

**Хоёр. Аймгийн ЗДТГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ж.Алтанцэцэг танаа**

1. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтыг хэрэгжүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр бэлтгэж, жилийн эцэст гарсан үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулж, дүн шинжилгээ хийж, аймгийн хэмжээнд нэгтгэн Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4-т заасны дагуу аймгийн Төрийн аудитын газарт 2022.04.01-ний дотор ирүүлэх.

